Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежментийн систем

Оролцогч талуудыг татан оролцуулах менежментийн төлөвлөгөө

АГУУЛГА

1 ТАНИЛЦУУЛГА 5
1.1 Оршил 5
1.2 Хамрах хүрээ ба зорилтууд 5
1.3 Бусад менежментийн төлөвлөгөөнүүдтэй давхцах байдал 6
1.4 Эрх мэдэл ба удирдлага 6
2 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА 6
2.1 Төслийн байршил ба нийгмийн асуудлууд 6
2.2 Төслийн бүс 7
3 ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА 7
3.1 ОТТОТ-г хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэг, хариуцлага 7
4 ТӨСЛИЙН СТАНДАРТУУД 8
4.1 Монгол Улсын холбогдох хууль тогтоомж 8
4.2 Олон улсын холбогдох стандарт, удирдамжууд 9
4.2.1 Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк 9
4.3 Сентерра компанийн холбогдох стандартууд 9
4.4 Гацуурт төслийн хүрээнд дагаж мөрдөхөөр амлалт авсан салбарын бусад удирдамжууд 10
5 ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫГ ТОДОРХОЙЛОХ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ТАТАН ОРОЛЦУУЛАХ АРГА ЗҮЙ 10
5.1 Оролцогч талуудыг тодорхойлох ба тэдгээрт дүн шинжилгээг хийх 10
5.2 Оролцогч талуудыг татан оролцуулах арга хэлбэрүүд 13
5.3 Талуудыг татан оролцуулах ажлын ерөнхий тойм 15
5.3.1 Төслийг урьд өмнө олон нийтэд танилцуулж байсан арга хэмжээнүүд 15
5.3.2 БОННУ-ний үе шатан дахь оролцогч талуудын оролцоо 15
5.4 Оролцогч талуудыг татан оролцуулах чиглэлээр одоо хэрэгжиж байгаа болон цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөтөлбөр 16
5.4.1 БОННУ-ний хүрээнд хийх зөвлөлдөх уулзалт, олон нийтэд танилцуулах арга хэмжээ 16
6 ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ БАРАГДУУЛАХ МЕНЕЖМЕНТ 21
6.1 Зорилго 22
6.2 Зорилтууд 22
6.3 Хамрах хүрээ 22
6.4 Өргөдөл, гомдол барагдуулах механизм хэрэгжих үйл явц 22
6.5 Өргөдөл, гомдол шийдвэрлэх хугацаа 24
6.6 Өргөдөл, гомдол шийдвэрлэх механизмын тухай нийтэд мэдээлэх 25
6.7 Өргөдөл, гомдол барагдуулах үйл явц хангалттай байсан гэдгийг хүлээн зөвшөөрөх 25
6.8 Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх бусад боломжууд 25
6.9 Компани дотор өргөдөл, гомдлыг удирдах, дүн шинжилгээ хийх, урьдчилан таамаглах 25
7 КОМПАНИТАЙ ХОЛБОО БАРИХ 26
Хавсралт 1: Маягт 1 “Өргөдөл, гомдол хүлээн авах хуудас” 27
Хавсралт 2: Маягт 2 “Шийдвэрийг хүлээн зөвшөөрсөн тухай хуудас” 28

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

ТОВЧЛОЛ

Товчлол	
БГК	Бороо Гоулд компани
ОНОТБ	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн байгууллага
Сентерра	Сентерра Гоулд
БОНБНҮ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ
ЕСБХБ	Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк
БОНҮ	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ
БОННҮ	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ
БОНМТ	Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
ТББ	Төрийн бус байгууллага
ОТТОТ	Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Нэр томьёоны тайлбар	
Хэлэлцүүлэг	Төслийн талаар шийдвэр гаргах, зорилтот түвшинг тогтоох, стратеги тодорхойлох үед талуудаас мэдээлэл цуглуулах эсвэл зөвлөгөө авах, тэдний санал бодлыг харгалзан үзэх үйл явц.
Харилцан ярилцлага	Стратеги эсвэл аливаа шинэ санаа санаачилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн харилцан ойлголцол, итгэлцэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх, мөн олон талт төлөвлөгөө, хэрэгцээ, хувилбаруудын талаарх ойлголтыг эрэлхийлэхийн тулд үзэл бодол, саналаа солилцох
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн байгууллагууд	Олон нийтийн гишүүдээс бүрдсэн, олон нийтээс санаачлан байгуулсан байгууллагыг хэлнэ. Тухайлбал, фермерийн хоршоо нь олон нийтийн оролцоонд түшиглэсэн байгууллагуудын жишээ юм.
Компанийн нийгмийн хариуцлага	Компаниуд өөрсдийн бизнесийн үйл ажиллагаа болон оролцогч талуудтай харилцахдаа нийгэм, байгаль орчны асуудлуудыг тусгах шаардлагатай гэсэн үзэл баримтлал.
Орон нутагт хийх нийгмийн хөрөнгө оруулалт	Орон нутагт хийх нийгмийн хөрөнгө оруулалт гэж бизнесийн байгууллага үйл ажиллагаагаа явуулж байгаа тухайн орон нутгийн иргэдийн хэрэгцээг хангах үүднээс хэрэгжүүлж буй нийгэм рүү чиглэсэн санал санаачилга болон амлалтуудыг хэлнэ. Энэ нь тухайн компанийн хариуцлагатай бизнес эрхэлж нийгэмд эерэг хувь нэмэр оруулж байгаа гэдгээ харуулах хэрэгсэл болж байдаг. Нийгмийн хөрөнгө оруулалт нь орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд чухал хувь нэмэр оруулах институцийн болон чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагаанд голдуу чиглэсэн байдаг. Дэмжлэг нь олон төрлийн байж болох бөгөөд тухайлбал, тухайн компанийн бизнесийн үндсэн үйл ажиллагаанаас гадуур оролцогч талуудад үр ашиг авчрах зорилгоор иргэний нийгмийн асуудлууд, орон нутгийн стратегийн хамтын ажиллагаа, боловсрол, сургалт хөгжил, бизнес болон аж ахуйн нэгжийг хөгжүүлэх зэрэг хэлбэртэй байдаг. Үр шим хүртэгчид нь орон нутгийн, үндэсний болон олон улсын оролцогч талууд зэрэг олон төрлийн байж болдог.
Татан оролцуулах	Төсөл хэрэгжих нийт хугацаанд компанийн үйл ажиллагааны улмаас нөлөөлөлд өртсөн талуудтай бүтээлч, тогтвортой харилцааг бий болгож дэмжихэд чиглэсэн үйл явц. Энэ нь “оролцогч талуудыг татан оролцуулах” буюу тэдгээрийн оролцоог хангахад чиглэсэн өргөн хүрээтэй стратегийн нэг хэсэг бөгөөд төрийн байгууллагууд, иргэний нийгэм, компанийн ажиллагсад, бэлтгэн нийлүүлэгчид болон төсөлд аливаа сонирхол бүхий бусад талуудад хамаарна.
Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ	Энэ нь төслийн нөлөөллүүдийг тодорхойлох, төслийн сөрөг нөлөөллийг бууруулах, мөн эерэг нөлөөллийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг боловсруулах зорилготой байгаль орчны болон нийгмийн олон төрлийн судалгаануудаас бүрдсэн үнэлгээ юм.

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

Уурхайн амьдралын мөчлөг	Одоогийн уурхайн төлөвлөгөөн дээр үндэслэн хүдэр олборлох, баяжуулахын тулд уурхайн үйл ажиллагааг төлөвлөж байгаа нийт хугацаа (жил).
Амьжиргаа	Өрхүүд өөрсдийн өдөр тутмын хэрэгцээгээ хангахад чиглэсэн санхүүгийн эсхүл амь зуулгын үйл ажиллагаа. Ерөнхийдөө хөдөө орон нутгийн айл өрхүүд мал аж ахуй эрхлэх, мөн албан бус худалдаа хийх зэрэг амьжиргаагаа хангах хэд хэдэн аргатай байдаг.
Орон нутгийн иргэд/бүлэг	Төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй тухайн төслийн талбай ойр орчим амьдарч буй хэсэг бүлэг хүмүүсийг хэлнэ. (Харин "оролцогч талууд" гэж төслийг сонирхож буй хүмүүс болон байгууллагуудыг хамарсан өргөн хүрээний төлөөллийг голдуу ойлгодог.)
Төрийн бус байгууллагууд	Орон нутгийн хөгжлийг дэмжих, орон нутагт чадавхийг бий болгох, нөлөөллийн арга хэмжээ авах, байгаль орчныг хамгаалах чиглэлээр ажилладаг ихэвчлэн ашгийн төлөө бус хувийн байгууллагууд.
Түншлэл	Оролцогч талуудыг татан оролцуулах, тэдгээрийн оролцоог хангах үйл ажиллагааны хүрээнд түншлэл гэж нэг зорилгод хүрэхийн тулд хүмүүс болон байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг хэлэх бөгөөд ингэхдээ нөөц, чадавхи, эрсдэл болон ашиг тусаа түншүүд хуваалцаж байдаг.
Төслийн бүс	Төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор шууд болон шууд бус нөлөөлөл үүсч болох газар зүйн бүс. Ерөнхийдөө төслийн бүс нь (а) тухайн төслийн хувьд онцлог шинжтэй; (б) төслийн бодит нөлөөлөл буюу ул мөрөөс их байхын зэрэгцээ нийгэм-эдийн засгийн асуудлууд болон нөлөөллүүдээс гадна бусад нөлөөллүүдийг (жишээ нь, байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал) мөн адил хамаарч байдаг. Төслийн бүсийг тодорхойлох зорилго нь төслийн бүсийн нөлөө, хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход оршдог. Үүнээс гадна тухайн бүс дэх нөлөөллийг удирдах, хяналт тавихад удирдамж болохын зэрэгцээ БОННҮ хийх явцад оролцуулах шаардлагатай төслийн оролцогч талуудыг тодорхойлоход ач тустай байдаг.
Оролцогч тал	Нөлөөлөл үзүүлэх боломжтой, эсвэл компани болон түүний үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн иргэдийн бүлэг эсвэл хувь хүн.
Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө	Уурхайн амьдралын мөчлөгийн туршид оролцогч талуудыг идэвхтэй татан оролцуулах, уг оролцоог ханган нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажилллагааг тодорхойлсон төлөвлөгөө.

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ.

1 ТАНИЛЦУУЛГА

1.1 Оршил

Сентерра Голд ХХК (цаашид “Сентерра” гэх) компани нь Гацуурт төслийг өөрийн охин компани болох Бороо Гоулд компаниар (цаашид “БГК” гэх) дамжуулан 100% бүрэн эзэмшдэг. Сентерра нь 2004 оноос хойш Торонтогийн хөрөнгийн бирж дээр бүртгэгдсэн хувьцаат компани юм. Тус компани хувьцаа эзэмшигчдийнхээ үнэ цэнийг нэмэгдүүлэн ашигтайгаар ажиллахын зэрэгцээ Монгол Улс болон бусад улсад явуулж буй үйл ажиллагаандаа компанийн нийгмийн хариуцлагын тэргүүн туршлагыг хэрэгжүүлэх зорилго тавин ажилладаг. Гацуурт төсөл нь 2004 онд үйл ажиллагаагаа эхлүүлж, 2012 онд олборлолтоо дуусгасан Бороо гоулд алтны уурхайгаас 35 км-ийн зайд оршдог. Бороо гоулд алтны уурхайн талбайд үлдсэн хүдрийн овоолгын ашиглалт дуусах шатандаа явж байна. Гацуурт нь Бороогийн уурхайн талбайтай 55 км замаар холбогдсон бөгөөд энэ замыг Мандал сумтай гэрээ байгуулж 2010 онд барьж дуусан.

Сентерра нь уг төслөө хэрэгжүүлэхийн тулд Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (ЕСБХБ)-наас төслийн санхүүжилт авахаар зорьж байна. Сентерра нь төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг авахын тулд Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННҮ)-г хийлгэх ёстой билээ. Үүнээс гадна төсөл нь байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлыг хангах стандартуудыг тодорхойлсон ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлагуудыг хангах шаардлагатай.

Оролцогч Талуудыг Татан Оролцуулах Төлөвлөгөө (ОТТОТ)-ний эхний хувилбарыг Сентерра компанид зориулан Састэйнабилити ХХК боловсруулсан болно. Энэхүү төлөвлөгөөг Гацуурт төслийн БОННҮ-ний тайлангуудын хамт төслийг олон нийтэд танилцуулах багц тайлангуудын нэг хэсэг болгож ЕСБХБ-д хүргүүлээд байна. ОТТОТ-ний энэхүү эхний хувилбар нь оролцогч талуудыг татан оролцуулахад анхны удирдамж болох бөгөөд Сентерра компани төслийн барилгын үе шат эхлэхээс өмнө, мөн цаашдаа хаалт/нөхөн сэргээлт зэрэг төслийн бүхий л үе шатанд уг төлөвлөгөөг хянаж сайжруулах юм (өөрөөр хэлбэл ОТТОТ-ний эцсийн хувилбарыг боловсруулж батална). Энэ утгаараа уг ОТТОТ нь төслийн оролцогч талуудтай урт хугацааны харилцааг хадгалахын тулд тогтмол хянаж сайжруулагдах “амьд” баримт бичиг юм.

1.2 Хамрах хүрээ ба зорилтууд

Энэхүү ОТТОТ нь Гацуурт төслийн бүх үйл ажиллагаа, тэр дундаа гэрээт гүйцэтгэгчдийн үйл ажиллагаанд мөн адил хамаарна. Төлөвлөгөө нь оролцогч талуудтай зөвлөлдөх, төслийг олон нийтэд танилцуулж хэлэлцүүлэг хийх, өргөдөл, гомдол барагдуулах явцад тухайн орон нутгийн соёл зан заншилд тохирсон арга замыг тодорхойлох зорилготой юм. ОТТОТ-ний зорилго шийдвэр гаргах үйл явцыг дэмжиж сайжруулах, төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүс болон бусад оролцогч талуудыг нэгдсэн ойлголттой болгох зорилгоор мэдээллийг цаг алдалгүй өгөх, харилцан бие биеэ ойлгосон орчинг бүрдүүлэх, эдгээр бүлгүүд Төслийн талаар өөрсдийн санал, үзэл бодлоо илэрхийлэх өргөн боломжийг олгоход оршиж байна.

Энэхүү төлөвлөгөөний тодорхой зорилтуудыг дор дурдав, үүнд:

- Төслийн бүсийг тодорхойлох;
- Нөлөөлөлд өртсөн талууд болон Төслийг сонирхож байгаа бусад талуудыг тодорхойлох, зураглах, үнэлэх, хэрхэн Төслийн нөлөөлөлд өртөж болохоос гадна Төслийн талаар ямар сонирхол агуулж болохыг тодорхойлох;
- Төслийн оролцогч талууд, эдгээр нь хэрхэн өөр хоорондоо харилцаж байдгийг ойлгохын тулд талуудын дүн шинжилгээг хийх, ингэснээр тэднийг татан оролцуулах, оролцоог нь хангахад тохирсон арга, аргачлалыг боловсруулах;
- Талуудын зүгээс төсөлтэй холбоотойгоор гаргаж буй үнэ цэнэтэй санал, зөвлөмжийг төсөлд тусгахын тулд хэлэлцүүлэг зохион байгуулах төлөвлөгөөг боловсруулах;
- Сентерра болон орон нутгийн иргэдийн хооронд урт хугацааны харилцаа холбоог бий болгох;
- Талуудад Сентерра компанийн төслийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг цаг тухайд нь хүртээмжтэй хүргэж байх;
- Оролцогч талуудад төслийн талаар өгөх мэдээллийг ойлгоход хялбар байдлаар өгөх, хэлэлцүүлэг болох газар, байршил нь оролцохыг хүссэн бүх хүмүүст хүртээмжтэй байх;
- Өртөмхий болон эмзэг бүлгүүдийг (эмэгтэйчүүдийг оруулан) тодорхойлох, байнга зохион байгуулах хэлэлцүүлэгт тэднийг оролцуулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ

- Оролцогч талуудын зүгээс гарч буй асуулт, хөндөж буй асуудал болон өргөдөл, гомдлыг хүлээн авах тодорхой механизмыг бий болгох, мөн зөрчлийг шийдвэрлэх тодорхой үйл явцыг бий болгох;
- Орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудын дунд үүссэн хүлээлтийг шийдвэрлэх; болон
- Албан ёсны хэлэлцүүлэг, төслийг олон нийтэд танилцуулах уулзалтуудыг баримтжуулах, оролцогч талуудын талаарх мэдээллийг бүртгэх менежментийн тогтолцоог тодорхойлох.

1.3 Бусад менежментийн төлөвлөгөөнүүдтэй давхцах байдал

Энэхүү менежментийн төлөвлөгөө нь Гацуурт төсөлд зориулан боловсруулсан багц Менежментийн Төлөвлөгөөнүүдийн нэг хэсэг юм. Бороо гоулд уурхайд ашиглаж буй Аюулгүй ажиллагаа, Эрүүл мэнд, Байгаль орчны менежментийн ерөнхий системийг Гацуурт төсөл дээр хэрэгжүүлэх бөгөөд ингэхдээ нийгмийн асуудлууд, амлалтууд болон орон нутагтай харилцах чиг үүргүүдийг энд мөн адил хамруулж авч үзсэн болно. Үйл ажиллагааны стандарт журмууд нь менежментийн төлөвлөгөөнүүдэд суурилсан байдгаас гадна хяналт, мониторингийн гол аргачлалын талаар заасан тайлбарыг агуулсан болно.

Энэхүү Менежментийн төлөвлөгөө нь Орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөө; Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөө, Орон нутгийн хөдөлмөр эрхлэлт, сургалтын менежментийн төлөвлөгөө, Худалдан авах ажиллагаа, ханган нийлүүлэлтийн сүлжээний менежментийн төлөвлөгөө, Аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөө, Соёлын өвийн менежментийн төлөвлөгөөтэй гол гол асуудлаар давхцаж байна.

1.4 Эрх мэдэл ба удирдлага

Энэхүү менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг Гацуурт төслийн Ерөнхий Менежер хариуцна. Төслийн барилгын болон ашиглалтын эхний үед уг төлөвлөгөөг хамгийн багадаа хагас жилд (зургаан сар тутам) нэг удаа хянах ба цаашдаа жилдээ нэг удаа төслийн хэрэгжилт, мөн журамд орсон өөрчлөлтөд нийцүүлэхийн тулд өөрчлөлт хийх шаардлагатай эсэхийг тодорхойлж байх юм.
Энэхүү менежментийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах шаардлага гарсан тохиолдолд хүсэлтийг уг менежментийн төлөвлөгөөг хариуцсан менежерт хүргүүлж зохих журмын дагуу хянаж шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулж батална.

2 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2.1 Төслийн байршил ба нийгмийн асуудлууд

Гацуурт төсөл нь Улаанбаатар хотоос хойд зүгт 90 км, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгоноос баруун зүгт 14 км-ийн зайд байрлах Хэнтийн нурууны хөндийд оршдог. **Error! Reference s ource not found.**-д төслийн байршлыг үзүүлэв. Сентерра нь Бороо Гоулд уурхайгаас (одоогоор зөвхөн алт баяжуулах үйл ажиллагаа явуулж байгаа) 35-ийн км зайд байрлах Гацуурт төслийг 100% эзэмшдэг. Гацуурт төслийн одоогийн төлөвлөгөөгөөр Компани Гацууртын уурхайн талбайгаас хүдэр олборлож, Бороогийн уурхайн одоо ашиглаж буй бутлуурт тээвэрлэн авчирч боловсруулах юм. Гацуурт төслийн талбай болон Бороогийн уурхайг холбосон тээврийн зам, уурхайн туслах зам, уурхайнуудын байгууламжуудыг 2010 онд барьж дуусгасан.

Төсөл нь Монгол орны уулархаг хойд бүс нутаг буюу Орхон, Сэлэнгийн сав газарт байх Сэлэнгэ аймагт байрладаг. Аймгийн төв Сүхбаатар хот нь Улаанбаатар хотоос 321 км-ийн зайд оршдог бөгөөд хатуу хучилттай зам, төмөр замаар нийслэл хоттой холбогддог. Сэлэнгэ аймаг нь Монгол Улсын газар тариалангийн томоохон бүс нутаг бөгөөд уг аймагт Монголын газар тариалангийн газрын ихэнхи хэсэг нь байрлаж байна. Сүхбаатар хот нь ОХУ-ын хилийн боомт хүртэлх төмөр зам болон улсын чанартай замын огтлолцол дээр байрладаг учраас хөгжлийн гол тэнхлэг болж байна. 2014 оны байдлаар аймгийн хүн амын тоо 105,253 байв.

Мандал сум нь Сэлэнгэ аймгийн төв Сүхбаатар хотоос 220 км-ийн зайд, Улаанбаатар хотоос 174 км-ийн зайд оршдог, сумын төв нь Зүүнхараа. Хэрх багийн төв Зүүнхараагаас 5 км-ийн зайд оршдог бол Түнхэл баг Зүүнхараагаас зүүн өмнөд зүгт хучилтгүй замаар 44 км-ийн зайд байрладаг. Сумын газар нутгийн ихэнхийг нь газар тариалангийн зориулалтаар ашигладаг. Үүнээс гадна сумын нутаг

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ

дэвсгэрийн 70% нь ойн сан бүхий газар бөгөөд Мандал сумын аж үйлдвэрийн хоёрдогч гол салбар нь ойн аж ахуй юм.

Баянгол сум нь Улаанбаатар хотоос 156 км, Дархан–Уул аймгаас 75 км, аймгийн төвөөс 170 км-ийн зайд тус тус байрладаг. Баянгол сум Мандал сумтай нэгэн адил газар тариалангийн газар нутаг бөгөөд Улаанбаатар, Дархан хот, мөн Сэлэнгэ аймагтай хатуу хучилттай зам болон төмөр замаар холбогддог.

Зураг 1 Гацуурт төслийн байршил



2.2 Төслийн бүс

Гацуурт төслийн бүс гэж нийгэм-эдийн засгийн эсвэл соёлд шууд эсвэл шууд бус нөлөөлөл үүсч болох газрыг тодорхойлсон. Уг бүсэд Сэлэнгэ аймгийн Мандал, Баянгол сумдууд орж байгаа бөгөөд Түнхэл баг энд голлох бүс болж байна. Төслийн бүс нутаг дахь орон нутгийн бүлгийн талаарх дэлгэрэнгүйг Хэсэг 5.1.1-д байгаа Хүснэгт 2-оос үзнэ үү.

3 ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

3.1 ОТТОТ-г хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэг, хариуцлага

Тус төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг, хариуцлагыг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1 Гол үүрэг, хариуцлага

Хариуцагч	Хариуцлага
Гацуурт төслийн Ерөнхий Менежер	Энэхүү төлөвлөгөөнд тусгагдсан Төслийн Стандартууд болон бусад шаардлагуудыг ханган ажиллах. Энэхүү Төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах нөөцийг батлах
Гацуурт төслийн Гадаад харилцаа, Тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан захирал	Төлөвлөгөөний хамрах хүрээ, хэрэгжилтийг ерөнхийд нь хангах Энэхүү төлөвлөгөөг боловсруулах, хянах, эргэж харах
Орон нутгийн харилцааны ахлах мэргэжилтэн	Хэрэгжүүлэх байгууллагууд, бусад оролцогч талуудтай хамтран уг төлөвлөгөөг цаг хугацаанд нь хэрэгжүүлэх Төлөвлөгөөг хэрэгжүүлэх
Олон нутгийн харилцааны ажилтнууд	Олон нутгийн харилцааны ахлах мэргэжилтний зааварчилгааны дагуу оролцогч талуудыг татан оролцуулах, оролцоог хангах өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, зохицуулах
Гэрээт гүйцэтгэгчид	Гацуурт төслийн бодлого, журамд нийцсэн үйл ажиллагаа явуулах Хууль ёсны шаардлагын дагуу гэрчилгээ ба/эсвэл тусгай зөвшөөрлийг авах Гацуурт төслийн нийгмийн нөлөөллийг удирдах шаардлагуудыг биелүүлэх Холбогдох удирдлага, эсхүл удирдах эрх бүхий байгууллагад нийгмийн бодит болон болзошгүй бүхий л нөлөөллийн талаар тайлагнах Гэрээт болон туслан гүйцэтгэгчидтэй холбоотойгоор гаргасан өргөдөл, гомдол, оролцогч талуудыг татан оролцуулах, оролцоог нь хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн бүх арга хэмжээг холбогдох байгууллагад тайлагнах
Ажиллагсад	Боломжийн хэрээр өөрсдийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах Гацуурт төслийн бусад холбогдох байгаль орчны болон нийгмийн бодлого, журам, мөн уг Менежментийн Төлөвлөгөөнд заасан үүрэг, хариуцлагыг биелүүлэх Холбогдох удирдлага, эсхүл удирдах эрх бүхий байгууллагад байгаль орчин, нийгмийн бодит болон болзошгүй бүхий л нөлөөллийн талаар тайлагнах

4 ТӨСЛИЙН СТАНДАРТУУД

Сентерра нь олон улсын тэргүүн туршлагад тулгуурлан Монгол Улсын хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтын шаардлагуудад нийцүүлэн Гацуурт төслийг хэрэгжүүлнэ. Оролцогч талуудыг татан оролцуулахтай холбоотой дараах үндсэн дүрэм журам, стандартуудыг баримтална. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын холбогдох бүх шаардлагууд, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнүүд;
- Сентерра компанийн бодлого, стандартууд;
- ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн Шаардлагууд (2014)[1]; ба
- Гацуурт төслийн Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө, бусад амлалтууд.

4.1 Монгол Улсын холбогдох хууль тогтоомж

Монгол Улсад оролцогч талуудыг татан оролцуулах, тэдгээрийн оролцог хангахтай холбоотой гол заалтууд дараах хууль тогтоомжид агуулагдсан байдаг, тухайлбал:

[1] http://www.ebrd.com/news/publications/policies/environmental-and-social-policy-esp.html харна уу.

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ

- **Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (1998 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөж, 2001, 2006, 2012 онуудад нэмэлт өөрчлөлт оруулсан):**
  Уг хуулийн олон нийттэй холбоотой гол заалт нь олон нийтийн оролцоотой холбоотой зохицуулалт юм, уг зохицуулалтын дагуу төсөл хэрэгжүүлэх аливаа этгээд төслийн талаар олон нийттэй өргөн хүрээнд зөвлөлдөх шаардлагатайн зэрэгцээ олон нийттэй зөвлөлдөх явцад хөндөж тавьсан асуудлуудыг зураг төсөл боловсруулах үед тусгах ёстой юм.

- **Ашигт малтмалын тухай хууль (2006 оны 6 дугаар сарын 26–ны өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж байна):**

  Ашигт малтмалын тухай хуульд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, дэд бүтэц хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана гэж заасан байдаг. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дээр дурьдсан асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран олон нийтийн хэлэлцүүлэг явуулж болно. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий төлөөлөгчийг иргэд дундаасаа сонгон ажиллуулж болох юм.

4.2 Олон улсын холбогдох стандарт, удирдамжууд

4.2.1 Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк

ЕСБХБ нь Байгаль орчин, нийгмийн бодлого (2014 оны 5-р сар) болон “Гүйцэтгэлийн Шаардлага 10: Мэдээллийг ил тод болгох, оролцогч талуудын оролцоог хангах”-д заасны дагуу байгаль орчны хувьд ээлтэй болон тогтвортой хөгжлийг хангах үүрэг хүлээсэн байдаг. ЕСБХБ-наас талуудын оролцоог хангахад тавьдаг шаардлагыг дараах баримт бичгүүдэд тусгасан болно. Үүнд:

- Байгаль орчин, нийгмийн бодлого (2014);
- Олон нийтийн мэдээллийн бодлого (2014); болон
- ГШ 10 Мэдээллийг ил тод болгох, оролцогч талуудыг татан оролцуулах (2014).

ЕСБХБ нь олон нийтийн хэлэлцүүлэг хийх, оролцогч талуудыг татан оролцуулж тэдгээрийн оролцоог хангах үйл ажиллагааг байнгын үйл явц бөгөөд үүнийг байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх эхний үе шатаас эхэлж хийхээс гадна ЕСБХБ-ны санхүүжилттэй төсөл хэрэгжих бүхий л хугацаанд үргэлжлүүлэх ёстой хэмээн үздэг.

Үр дүнтэй хэлэлцүүлэг хийхийн тулд талуудтай зөвлөлдөх үйл ажиллагааны нэн чухал хэсэг бол бүх оролцогч талуудыг сайтар тодорхойлж, тэдгээрийн санаа зовоосон асуудал, хүлээлт, мөн илүү гэж үзсэн асуудлуудыг сайтар судлах явдал байдаг. Компанийн үйл ажиллагаанаас амьдрал, сайн сайхан байдал нь шууд хамаарах эмзэг бүлгийн оролцогчдыг тодорхойлоход онцгой анхаарал хандуулах шаардлагатай. Эдгээр оролцогч бүлгүүдтэй хэлэлцүүлэх хийх, зөвлөлдөх, харилцан яриа өрнүүлэхдээ анхааралтай хандаж нарийн төлөвлөх нь чухал байдаг.

Түүнчлэн ЕСБХБ-наас оролцогч талуудын гаргасан аливаа өргөдөл, гомдлыг түргэн шуурхай, цаг тухайд нь хүлээн авч барагдуулах үр дүнтэй өргөдөл, гомдлын механизмыг бий болгохыг төсөл хэрэгжүүлэгчээс шаарддаг.

Орон нутгийн иргэдтэй ойр дотно харилцаа тогтоож уг харилцааг хадгалах, тэдгээрийн хөгжлийг дэмжих нь ЕСБХБ-аар дамжуулан зээл авч байгаа бүх компаниудын бодлого, үйл ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг байх шаардлагатай байдаг. Нийгмийн хөрөнгө оруулалтад тавих ямар нэг тодорхой шаардлага байдаггүй ч гэсэн компаниудыг энэ чиглэлд ажиллахыг хөхиүлэн дэмждэг. Нийгмийн шинжтэй хөрөнгө оруулалтын талаар тусгайлсан шаардлага байдаггүй ч гэсэн ийм төрлийн хөрөнгө оруулалт хийхийг дэмждэг юм.

4.3 Сентерра компанийн холбогдох стандартууд

Сентерра нь 2004 оноос Торонтогийн хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй хувьцаат компани болохынхоо хувьд “Удирдлагын зарчмууд”-ын хүрээнд бүх үйл ажиллагаагаа явуулдаг, өөрөөр хэлбэл Гацууртын төслийг 100% эзэмшигч компани болохынхоо хэрээр эдгээр зарчмыг уг төсөлдөө мөн адил мөрддөг. Сентерра компани нь удирдлагынхаа хамгийн дээд түвшинд Захирлуудын Ёс

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ

зүйн дүрмийг мөрддөг ба үр дүнтэй компанийн засаглалыг хэрэгжүүлэх үүднээс Удирдах зөвлөлийг менежментийн багаас ангид байж бие даан ажиллах боломжийг бүрдүүлэх зэрэг тодорхой үйл ажиллагааны журмыг баталж мөрдлөг болгодог.

Компани үйл ажиллагаагаа явуулдаг тухайн улсын орон нутгийн иргэдтэй харилцахдаа Компанийн Хариуцлагын Стандартууд болон Удирдамжуудыг мөрдлөг болгодог. Уг стандартууд болон удирдамжуудад Сентерра компанийн бүх төсөл, үйл ажиллагаанд үндсэн чухал асуудлаарх компанийн амлалтыг тодорхойлох, эрсдлийг үнэлэх, цаашдын бизнесийн хөдөлгөх хүчийг тодорхойлох шаардлагыг тавьсан байдаг.

4.4 Гацуурт төслийн хүрээнд дагаж мөрдөхөөр амлалт авсан салбарын бусад удирдамжууд

Сентерра компани ОУСК-аас хэвлэн гаргасан *"Оролцогч талуудыг татан оролцуулах нь: Шинээр гарч ирж буй зах зээлд бизнес эрхлэж буй компаниудад зориулсан сайн туршлагын гарын авлага"*–д[2] тодорхойлсон хүртээмжтэй, үр дүнтэй оролцооны гол зарчмуудыг дор дурдсан байдлаар хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн. Үүнд:

- Зорилтот оролцогч талуудын бүлгүүдийн хэрэгцээнд тохирсон, ойлгоход хялбар, ойлгомжтой байдлаар хэрэгцээт мэдээллээр хангах;
- Хэлэлцүүлэг хийх, шийдвэр гаргахын өмнө мэдээллээр хангах;
- Соёлын хувьд зохистой, хялбар байдлаар, хүрэх боломжтой байршлыг сонгон мэдээллийг оролцогч талуудад хүргэх;
- Орон нутгийн уламжлал, хэл соёл, цаг хугацаа, шийдвэр гаргах үйл явцыг хүндэтгэн үзэх;
- Талуудад аль алиных нь үзэл бодол, харилцан мэдээллээ солилцох, бие биенээ сонсгох, өөрсдийн асуудлыг тавьж шийдвэрлэх боломжийг олгосон хоёр талт яриа хэлэлцээр өрнүүлэх;
- Янз бүрийн насны бүлэг, хүйс, жендэр, эмзэг байдал болон/эсвэл цөөнхийн бүлгийн үзэл бодлыг сонсох үүднээс тэдгээрийн төлөөллийг оролцуулах;
- Айлган сүрдүүлэх, дарамтлах эсвэл урамшуулласан ангид үйл ажиллагаа явуулах;
- Хүмүүсийн хөндөж буй асуудал, санал, гомдолд хариу өгөх ил тод механизм бий болгох; ба
- Төсөл эсхүл хөтөлбөрийг боловсруулахдаа боломжит саналыг аль болох боломжийн хэрээр тусгаж оролцогч талуудад эргэн тайлагнах.

Компани өөрийн үйл ажиллагаагаараа дамжуулан компанийн нийгмийн хариуцлагыг дараах чиглэлээр хэрэгжүүлэх үүрэг хүлээгээд байна. Үүнд:

- Өөрийн үйл ажиллагаа явуулдаг Монгол болон Киргиз улсуудад Олборлох салбарын ил тод байдлын санаачлага (ОҮИТБС)-ын зарчмуудыг дагаж мөрдөх:
- Даяар тайлагнах санаачлага (GRI)-ын G3 индекс, мөн "Уул уурхай, металлын нэмэлт" салбарын удирдамжийг баримтлан үйл ажиллагаагаа олон нийтэд ил тод болгох,
- Дэлхийн Алтны Зөвлөлөөс гаргасан Зөрчлөөс ангид алтны стандартыг нэвтрүүлж хэрэгжүүлэх;
- Алт олборлогч болон цианид ачаа илгээгч/тээвэрлэгчийн хувьд цианидын менежментийн олон улсын стандарт болох Цианидын Кодыг мөрдөх; ба
- Аюулгүй байдал, хүний эрхийн сайн дурын зарчмуудыг хүлээн зөвшөөрч даган мөрдөх зэрэг багтана.

5 ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫГ ТОДОРХОЙЛОХ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ТАТАН ОРОЛЦУУЛАХ АРГА ЗҮЙ

5.1 Оролцогч талуудыг тодорхойлох ба тэдгээрт дүн шинжилгээг хийх

Оролцогч талуудын дүн шинжилгээний гол зорилго нь оролцогч бүлэг тус бүрийг тодорхойлох, Төсөлтэй холбоотой тэдгээрийн үүрэг, хариуцлагыг зааж өгөх, оролцогч талуудыг татан оролцуулснаар гарах боломжуудыг гаргаж танилцуулах, оролцооны үед гарах эрсдлийг тоймлох

[2] Олон Улсын Санхүүгийн Корпораци, 2007 он. "Оролцогч талуудыг татан оролцуулах нь: Шинээр гарч ирж буй зах зээлд бизнес эрхлэж буй компаниудад зориулсан сайн туршлагын гарын авлага".

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ

явдал юм. Оролцогч талуудын оролцоог хангасан дүн шинжилгээ чухал боловч төслийн нөлөөлөл, нөлөө, ашиг сонирхлын түвшний дагуу эрэмбэлэх нь чухал байдаг.

Гацуурт төслийн хүрээнд дараах үндсэн оролцогч бүлгүүдийг тодорхойлсон ба эдгээр бүлэг тус бүрийг доор илүү дэлгэрэнгүй авч үзэв. Үүнд:

Төслийн гаднах буюу гадаад оролцогч талууд:

- Нөлөөлөлд өртсөн нутгийн иргэд;
- Малчид;
- Эмзэг бүлгүүд;
- Төрийн албан хаагчид ба орон нутгийн засаг захиргаа;
- Олон улсын болон үндэсний ТББ-ууд болон ОНОТБ-ууд;
- Үйлдвэрчний эвлэл;
- Бизнесийн холбоод;
- Хүрээлэн, эрдэм шинжилгээний байгууллагууд
- Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд
- Зээлдэгч;
- Ханган нийлүүлэгч/бизнес эрхлэгчид;
- Бичил уурхайчид.

Төслийн дотоод оролцогч талууд:

- Төслийн ажилтнууд
- Гэрээт гүйцэтгэгчид
- Үйлчилгээ, бараа бүтээгдэхүүн нийлүүлэгчид

Төслийн бүсэд шууд нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэд гэдэгт Мандал, Баянгол сумдууд, тэр дундаа Түнхэл багийн иргэд, мөн уурхайн талбай болон Гацууртын хүдэр тээвэрлэх зам орчимд амьдарч буй малчин өрхүүд (нүүдлийн болон хагас суурьшсан) орно. Энэхүү нөлөөллийн үндсэн бүсийн ойр орчимд байгаа зарим өрхүүд илүү шууд нөлөөлөлд (эерэг болон сөрөг) өртөнө. Дараах талуудыг төслийн нөлөөллийн үндсэн бүсэд шууд нөлөөлөлд өртсөн гэж тодорхойлсон. Үүнд:

Хүснэгт 3 Шууд нөлөөлөлд өртөж буй суурин газруудын жагсаалт

Суурин газар	Төрөл	Хүн ам	Гацуурт талбай хүртэлх зай	Бороогийн талбай хүртэлх зай
Баруунхараа	Баянгол сумын төв	5,594 (1,675 өрх)	Сайжруулсан замаар 76.4 км	Сайжруулсан болон засмал замаар 32.8 км
Зүүнхараа	Мандал сумын төв	25,693 (7,382 өрх)	Сайжруулсан замаар 39.2 км	Сайжруулсан замаар 49.4 км
Түнхэл баг	Мандал сумын багийн төв	3,234 (923 өрх)	Сайжруулсан шороон замаар ойролцоогоор 70 км (Зүүнхараагаар дамжин) / сайжруулаагүй замаар 18 км (Балж голоор дамжин)	Сайжруулсан шороон замаар ойролцоогоор. 90 км (Зүүнхараагаар дамжин)
Хөдөөгийн малчин өрхүүд	Улирлаар нүүдэл хийдэг болон хагас суурьшсан өрхүүд	49 (18 өрх)	(<1-ээс 100+ км)-т хэлбэлзэнэ	(<1-нээс 100+км)-т хэлбэлзэнэ
Бичил уурхайчид[3]	Төслийн бүсэд зохион байгуулалтад орсон болон албан бусаар гар олборлолт эрхэлж байгаа бичил уурхайчид	тогтмол биш	Янз бүр	Янз бүр

Хүснэгт 4-д Сентерра компаниас тодорхойлсон оролцогч талууд болон нөлөөлөлд өртсөн бусад гол талуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тусгав.

[3] Энд талбай руу дайран орсон болон хууль бус олборлогчдыг оруулаагүй бөгөөд Нийгмийн менежментийн төлөвлөгөөнд эдгээр бичил уурхайчдад авах хэмжээг тодорхой заасан болно.

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ

Хүснэгт 4 Оролцогч талууд болон нөлөөлөлд өртсөн бусад талууд

Оролцогч бүлгүүд	Гол оролцогч талууд	Тодорхой сонирхлын хураангуй
Засгийн газар (Үндэсний хэмжээнд)	Уул уурхайн яам Байгаль орчин, ногоон хөгжлийн яам[4] (үүнд: Цаг уур, орчны шинжилгээний газар, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний газар, Ус сувгийн удирдах газар) Эрүүл мэндийн яам Барилга, хот байгуулалтын яам (Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар), Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам Зам, тээврийн яам (үүнд: Төмөр замын удирдах газар, Зам тээврийн газар) Хууль зүйн яам (Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар) Боловсрол, шинжлэх ухааны яам Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын харьяа Байгаль орчин, аялал жуулчлал, геологи, уул уурхайн хяналтын газар болон Барилга, дэд бүтцийн хяналтын газар гэх мэт; Цагдаагийн байгууллага	Улсын ашигт малтмалын бодлого, Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудал Газрын нөхөн сэргээлт Байгаль орчин, усны бодлого. Хяналт шинжилгээ, хэрэгжилтэнд хяналт тавих чиг үүрэг хэрэгжүүлэх: Ажиллагсдын эрүүл мэндийн асуудал, олон нийтийн аюулгүй байдал Газартай холбоотой асуудлууд Зам тээвэртэй холбоотой асуудлууд Гадаад ажилчидтай холбоотой асуудлуудын зохицуулалт Соёлын өвийг хамгаалах асудлууд Хяналт шинжилгээ ба хэрэгжилтэнд хяналт тавих чиг үүргийн дагуу гүйцэтгэх
Төрийн байгууллага (Бүс нутгийн болон орон нутгийн)	Бүх түвшиний (аймаг, сум, баг) нутгийн өөрөө удирдах байгууллагууд (ИТХ); Засаг даргын тамгын газар	Байгалийн нөөцийн менежментийн зөвшөөрөл хүсэх, статистик тайланг гаргах Бүх төрлийн тусгай хамгаалалтын бүс бий болгох (усны хамгаалалтын бүс гэх мэт) Байгалийн нөөцийн ашиглалттай холбоотой жилийн зөвшөөрөгдөх хэмжээг тодорхойлох (аймаг, сумын) Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй холбоотой менежментийн арга хэмжээг аймаг, сум, багийн Засаг дарга нар болон ИТХ-ын хяналт дор авч хэрэгжүүлэх
Төрийн бус байгууллагууд/олон нийтийн оролцоонд түшиглэсэн байгууллагууд	“Түнхэл казак”; “Итгэлийн үг”; Бичил уурхай эрхлэгчдийн нөхөрлөл; Ой хамгаалагчид;“Түнхэлийн өглөө” ТББ; “Ноён уулаа аваръя” хөдөлгөөн; Олон улсын ТББ-ууд; Малчдын бүлгүүд (сум, багийн түвшинд) Бэлчээр ашиглагч бүлгүүдийн сумын холбоо Бичил уурхайчдын холбоо	Эдгээр бүлгүүдэд Төслийн одоогийн болон боломжит түншүүд, эсвэл Төсөлд нөлөөлөх сонирхолтой бүлгүүд багтана. Тухайн орон нутгийн зарим нэг төлөөлөлтэй хамтран олон улсын болон үндэсний хэд хэдэн ТББ-ууд уг Төслийг сонирхож байгаа, эсхүл Төсөлд аль хэдийн оролцож эхэлсэн.

[4] Яамдуудын нэрийг тухайн үеийн хуучин нэрээр оруулсан болно.

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ

Оролцогч бүлгүүд	Гол оролцогч талууд	Тодорхой сонирхлын хураангуй
Бусад сонирхлын бүлгүүд (Их сургуулиуд, бодлого судлалын төвүүд (think tanks) эрдэм шинжилгээний байгууллагууд гэх мэт)	ШУ-ны академи (археологичид болон химийн инженер); Археологийн хүрээлэн; Монгол Улсын Их сургууль	Нөлөөллийн менежмент зэрэг нарийн мэргэжлийн асуудлыг сонирхоно. Компанид мэргэшсэн салбарын чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх. Үндэсний хэмжээнд үзэл бодол боловсруулагчид.
Олон улсын болон дотоодын хэвлэл мэдээллийн хэрэгслүүд	Радио, телевизийн өргөн нэвтрүүлгүүд: Телевизүүд: Монголын Үндэсний телевиз, TV9, MN 25, TV5 Радио станцууд: FM 101.5 “Миний гэр”, Монголын үндэсний олон нийтийн радио	Нөлөөллийн менежмент гэх мэт чиглэлээр төслийн үйл ажиллагааг сонирхоно. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь Компанийн нэр хүндэд нөлөөлөх боломжтой байдаг. Үүнээс гадна хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь Компанид оролцогч талуудтай харилцах форум буюу чухал суваг бий болгох чадвартай байдаг.
Улс төрийн намууд	аймаг, сумын ИТХ дахь гол улс төрийн намуудын төлөөлөл	Эдийн засгийн болон нийгмийн хөгжил
Орон нутгийн иргэд	Сонгогдсон төлөөлөгчид болон орон нутгийн идэвхтнүүд Ахмадын хороо Орон нутгийн оршин суугчид Малчид Бичил уурхайчид	Байгаль орчны чанар, газар эзэмших (шаардлагатай бол) ба нөхөн олговор, барилгажилтын үеийн замын хөдөлгөөн, ажлын байр, бусад эдийн засгийн үр ашиг, нийгэм/орон нутагт хөрөнгө оруулалт хийх боломжууд/санаачлагууд
Бизнесүүд болон бизнесийн холбоод	Худалдаа аж үйлдвэрийн танхим/бизнес эрхлэгчдийн холбоо гэх зэрэг	Бизнесийн боломжууд Тэдгээрийн үйл ажиллагаанд үзүүлэх боломжит нөлөөлөл Хуримтлагдах нөлөөлөл
Дотоодын оролцогч талууд	Төслийн ажилчид, гэрээт гүйцэтгэгчид, бараа үйлчилгээ ханган нийлүүлэгчид	Хөдөлмөр эрхлэлт/ гэрээ
Хөдөлмөрийн холбоод/Үйлд-вэрчний эвлэл	Хөдөлмөрийн холбоод/ Үйлдвэрчний эвлэл	Цомхотгол, сургалт, эрүүл мэнд ба аюулгүй байдал,цагаач ажилчид гэх мэт асуудлууд, нөхөн олговор

5.2 Оролцогч талуудыг татан оролцуулах арга хэлбэрүүд

Оролцооны бүхий л хэлбэрүүд нь тухайн оролцогч бүлэг тус бүрт тохирсон, соёлын хувьд хүлээн зөвшөөрөгдсөн байвал зүйтэй. Оролцогч талуудтай харилцаа холбоо тогтоох, тэдгээрээс мэдээлэл цуглуулах, тэдгээртэй зөвлөлдөх, төслийн талаарх мэдээллийг хүргэхийн тулд олон төрлийн оролцооны арга хэлбэрийг ашиглана. Хүснэгт 5-д оролцогч талуудыг татан оролцуулах янз бүрийн арга, хэлбэрүүдийг тоймлон тусгав.

Хүснэгт 5 Татан оролцуулах арга хэлбэрүүд

Татан оролцуулах арга	Арга хэлбэрийг ашиглах хамгийн зохистой хэлбэр	Оролцогч талуудын бүлэг
Мэдээллийн төв ба мэдээллийн самбар	• Төслийн ойр орчимд олон нийтэд зориулсан мэдээллийн салбар байршуулах	• Нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэд • ТББ-ууд болон ОНБ-ууд
Утас/имэйл/мессеж бичих	• Төрийн албан хаагчид, байгууллагууд, агентлагууд болон бусад компаниудад төслийн тухай мэдээлэл хүргэх • Уулзалтуудад талуудыг урьж оролцуулах	• Төрийн байгууллагын ажилтнууд • Нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэд • Эмзэг бүлгүүд • Ажиллагсад болон менежерүүд • ТББ-ууд болон ОНОТБ-ууд • Олон нийт/хэвлэл мэдээллийн хэрэгслүүд • Санхүүгийн байгууллагууд

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ

Татан оролцуулах арга	Арга хэлбэрийг ашиглах хамгийн зохистой хэлбэр	Оролцогч талуудын бүлэг
Хэвлэмэл мэдээ, телевиз болон радиогийн зар	• Нийт сонсогчдод болон бичиг үсэг тайлагдаагүй олон нийтэд төслийн тухай мэдээлэл тараах • Хэлэлцүүлгүүдийн талаар оролцогч талуудад мэдээлэх	• Нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэд • Эмзэг бүлгүүд • ТББ-ууд болон ОНОТБ-ууд • Олон нийт/хэвлэл мэдээллийн хэрэгслүүд
Ганцаарчилсан ярилцлагууд	• Үзэл бодол, саналыг нь сонсох • Маргаантай, эмзэг асуудлуудын талаар чөлөөтэй, итгэлтэй ярихад нь оролцогч талуудад туслах • Талуудтай найрсаг харилцаа тогтоох • Ярилцлагуудыг тэмдэглэх	• Төрийн байгууллагын ажилтнууд • ТББ-ууд болон ОНОТБ-ууд
Албан ёсны уулзалтууд	• Оролцогч бүлгүүдэд төслийн тухай мэдээлэл танилцуулах • Оролцогч бүлгүүдэд санал бодлоо хуваалцах боломж олгох • Өндөр түвшний талуудтай шударга харилцааг бий болгох • Нарийн техникийн шинжтэй баримт бичгүүдийг тараах • Оролцогч талуудын бүлэгт Төслийэ тухай мэдээлэл танилцуулах • Илтгэлүүдийг ашиглан уулзалтуудыг зохион байгуулах • Хэлэлцүүлэг, санал/асуулт, хариултуудыг бичиж авах	• Төрийн байгууллагын ажилтнууд • Санхүүгийн байгууллагууд
Олон нийттэй хийх уулзалтууд	• Бүхий л оролцогч талууд болон төслийн нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдэд Төслийн талаарх мэдээллийг танилцуулах • Оролцогч бүлгүүдэд санал бодлоо хуваалцах боломж олгох • Ойр хавийн орон нутгийн иргэдтэй харилцаа тогтоох • Төслийн талаарх техникийн бус хураангуй мэдээллийг түгээх • Илтгэл, тараах материал, видео буюу төслийн баримт бичгийн мэдээллийг ашиглан уулзалтуудыг зохион байгуулах • Санал/асуултууд, хариултууд, хэлэлцүүлгийг бичиж авах	• Нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэд • Эмзэг бүлгүүд • Олон нийт/хэвлэл мэдээллийн хэрэгслүүд
Семинар	• Оролцогч бүлгүүдэд төслийн тухай мэдээллийг танилцуулах • Оролцогч бүлгүүдэд санал бодлоо хуваалцах боломж олгох • Бүлгийн хэлэлцүүлэг хийхэд оролцооны хэлбэрүүдийг ашиглах, санал бодлоо уралдуулах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, зөвлөмж, стратеги боловсруулах • Хариултуудыг тэмдэглэх	• Ажиллагсад болон менежерүүд • Гэрээт гүйцэтгэгчид • Санхүүгийн байгууллагууд
Фокус бүлгийн уулзалтууд	• 8-15 хүнтэй жижиг бүлгээс суурь судалгааны зорилтот мэдээллийн талаар санал бодлыг нь сонсох • Ойр хавийн орон нутгийн иргэдтэй харилцаа тогтоох • Хэлэлцүүлэг явуулахдаа фокус бүлгийн ярилцлагын удирдамжийг ашиглах • Хариултуудыг тэмдэглэх	• Нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэд • Эмзэг бүлгүүд • Ажиллагсад болон менежерүүд • ТББ-ууд болон ОНОТБ-ууд
Судалгаанууд	• Тухайн оролцогч талын санал бодлыг сонсох • Суурь мэдээллийг цуглуулах	• Нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэд • Эмзэг бүлгүүд

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ

Татан оролцуулах арга	Арга хэлбэрийг ашиглах хамгийн зохистой хэлбэр	Оролцогч талуудын бүлэг
	• Мэдээллийг бүртгэж авах • Нөлөөлөлд хяналт-шинжилгээ хийхэд шаардлагатай суурь мэдээллийн бааз үүсгэх	• Ажиллагсад болон менежерүүд

5.3 Талуудыг татан оролцуулах ажлын ерөнхий тойм

Гацуурт төсөл нь Засгийн газар болон төслийн бүсийн ойр орчимд ажиллаж, амьдардаг орон нутгийн иргэдтэй хэлэлцүүлэг хийж байсан хорь гаруй жилийн түүхтэй билээ. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн БОНБНҮ-г хийх явцад орон нутгийн иргэдтэй хэлэлцүүлэг хийснээс гадна Сентерра компани өөрийн санаачилгаар нэмэлт хэлэлцүүлэг зохион байгуулсан. Гацуурт төсөл нь 2004 оноос хойш үйл ажиллагаа явуулж байгаа уурхайн жишгээр явж ирсэн бөгөөд хуульд заасны дагуу Төслийн БОНБНҮ тус бүрээр хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан.

5.3.1 Төслийг урьд өмнө олон нийтэд танилцуулж байсан арга хэмжээнүүд

Сентерра компаниас өөрийн төслийн үйл ажиллагааны улмаас болзошгүй нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдэд ач холбогдолтой, хүртээмжтэй мэдээлэл хүргэх үүрэг амлалтандаа хүрэхийн тулд олон нийтэд ил тод болгох төслийн материалыг боловсруулаад байна. Үүнд:

- Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу ил тод болгох шаардлагатай БОНБНҮ;
- Сентерра компанийн ажлын хамтарсан хэсгүүд, төрийн байгууллагууд, УИХ-ын гишүүд, орон нутгийн идэвхтнүүд, Орон нутгийн хөгжлийн сангийн түншүүд болон үр шим хүртэгчид, сум, багийн иргэдийн хурлууд[5]-ад зориулсан илтгэлүүд; болон
- 2011 онд боловсруулсан Сентерра компанийн олон нийтэд зориулсан гарын авлагаас гадна Зүүнхараа, Баруунхараа болон Түнхэл багт байрлах Сентерра компанийн мэдээллийн төвүүдээр дамжуулж орон нутгийн иргэдэд танилцуулах газрын зураг, хэвлэмэл материалууд.

5.3.2 БОННҮ-ний үе шатан дахь оролцогч талуудын оролцоо

Орон нутгийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний болон Нийгмийн нөлөөллийн үнэлгээг хийх явцад (ННҮ-г 2015 оны туршид хийсэн) оролцогч талуудын оролцоог байнга хангаж ирсэн билээ. Төсөл, мөн Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө (ОТТОТ)-тэй холбоотой хоёр тусдаа үе шаттайгаар талуудтай зөвлөлдсөн, тухайлбал:

- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний суурь судалгааны үед талуудын оролцоог хангах үе шат [6] (дуусан);
- Нийгмийн нөлөөллийн үнэлгээний суурь судалгааны үед талуудын оролцоог хангах үе шат (дуусан).

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний суурь судалгаанд оролцуулах үе шат

“Натур Фрейндли” ХХК-нь Гацуурт төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хүрээнд оролцогч талуудыг татан оролцуулах, зөвлөлдөх ажлыг 2014 онд хийсэн бөгөөд ингэхдээ дараах гол арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- Орон нутгийн малчид, иргэдтэй хийх уулзалт;
- Орон нутгийн засаг захиргааны (ИТХ болон багийн) төлөөлөл, удирдлагуудтай хийх уулзалт;
- УИХ-ын гишүүд, Монгол Улсын Засгийн газрын гишүүд, холбогдох албан тушаалтнууд, орон нутгийн иргэд болон орон нутгийн идэвхтнүүдийг Гацуурт төслийн бүстэй танилцуулах;
- Орон нутгийн мэдээллийн төвүүд дээр уулзалтууд хийх;
- Хэвлэмэл материал, баримт хуудас, сонины нийтлэлийг тараах; мөн
- Засгийн газрын Хамтарсан ажлын хэсгийн хуралдаанд танилцуулга хийх гэх мэт.

Нийгмийн нөлөөллийн үнэлгээний суурь судалгаанд оролцуулах үе шат

[5] Хамгийн сүүлд боловсруулсан, Гацуурт төслийн танилцуулгыг оролцуулаад. (2015 оны 3-р сарын 3).

[6] Төслийн БОНҮ болон ННҮ-г зэрэг хийгээгүй болно. БОНҮ-г 2014 хийсэн бол ННҮ-г 2015 онд хийсэн тул талуудтай зөвлөлдөх үйл явц тус тусдаа явагдсан.

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ

ННҮ-ний хүрээнд суурь судалгаа хийх үеэр (2015 оны 5-6 сард хийсэн) оролцогч талуудаас мэдээлэл цуглуулах, санал бодлыг нь авахад оролцогч талуудын оролцоог хангах ажил үндсэндээ чиглэж байсан. Нийгмийн суурь судалгаа хийхээс өмнө Төслийн гадаад болон дотоод гол оролцогч талуудын дунд анхан шатны зөвлөлдөх үйл ажиллагааг явуулсан. Дотоод гол оролцогч талуудтай Улаанбаатар хотод байрлах Сентерра компанийн төв байранд уулзалт хийх, мөн түүнчлэн анхан шатны баримт бичгийг судлах, Төслийн нөлөөллийн бүсийг үнэлэх зорилгоор төслийн талбайд Компанийн болон Зээлдүүлэгчийн гол төлөөлөлтэй зөвлөлдөх, мөн олон нийтийн дунд анхан шатны хэлэлцүүлэг хийх зэргээр оролцоог ханган ажилласан. 2015 оны 5-6 дугаар сард хийсэн нийгмийн суурь судалгааны хүрээнд өрхийн асуумж судалгаа авах, чухал буюу гол мэдээлэгчидтэй ярилцлага хийх, зорилтот бүлгийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулах зэргээр Төслийн оролцогч талуудыг өргөнөөр оролцуулсан. Энэхүү суурь судалгаа хийх үе шатанд дараах тодорхой зорилтуудыг тавьсан. Үүнд:

- Дараагийн үе шатуудад судалгаа хийх шаардлагатай болзошгүй нөлөөлөл, асуудлуудыг тодорхойлох;
- Төслийн оролцогч талуудыг нарийвчлан тодорхойлох;
- Суурь судалгаанд хамааралтай мэдээллийг тодорхойлох, цуглуулах;
- Санал болгож буй төсөл дээр оролцогч талуудын санал бодлыг авах, үнэлгээний явцад эдгээр саналыг анхаарч үзэх;
- Болзошгүй нөлөөллийг удирдах, бууруулах, ялангуяа оролцогч талууд эдгээр арга хэмжээнд идэвхтэй оролцох магадлалтай байгаа бол оролцогч талуудын санал бодлыг сонсох.

5.4 Оролцогч талуудыг татан оролцуулах чиглэлээр одоо хэрэгжиж байгаа болон цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөтөлбөр

5.4.1 БОННҮ-ний хүрээнд хийх зөвлөлдөх уулзалт, олон нийтэд танилцуулах арга хэмжээ

Төслийн байгаль орчин, нийгмийн холбогдох баримт бичгийг бүрдүүлсний дараа Сентерра компанийг санал болгож буй төслийн төлөвлөгөө, нөлөөлөл болон нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар оролцогч талуудаас санал авахын тулд төслийн байгаль орчин, нийгмийн асуудлаар олон нийтэд хангалттай мэдээлэл өгөхийг ЕСБХБ-наас шаарддаг. Зөвлөлдөх хугацаа хамгийн багадаа 60 хоног байна. Энэхүү зорилтонд хүрэхийн тулд Сентерра компани тодорхой бүлгүүдийн хэрэгцээнд чиглэсэн холбогдох баримт бичгийг мэдээллийн янз бүрийн сувгаар дамжуулан олон нийтэд ил тод болгоно.

Төслийн БОННҮ-г олон нийтэд танилцуулах багц нь орон нутгийн байгаль орчны зөвшөөрлийг авах зорилгоор боловсруулсан тайлан, баримт бичгээс бүрдэхээс гадна ЕСБХБ-ны шаардлагыг хангахын тулд боловсруулсан нэмэлт баримт бичгүүдийг мөн адил агуулсан болно. Эдгээр нэмэлт тайлангууд БОННҮ-тэй хамтдаа олон нийтэд танилцуулах багцад багтана. Үүнд:

1. Техникийн бус хураангуй;
2. Хуулийн дагуу батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангууд;
3. Нийгмийн нөлөөллийн тайлан;
4. Техник, эдийн засгийн үнэлгээний нэг хэсэг болсон Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ;
5. Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (энэхүү төлөвлөгөөг багтаасан);
6. Гацууртын бүс нутгийн биет бус соёлын өвийн угсаатан зүйн тайлан.

БОННҮ-ний тайланг олон нийтэд танилцуулах багцыг ЕСБХБ-ны вэб хуудас (www.ebrd.com) болон Сентерра/Бороо Гоулд компанийн вэб хуудсанд (http://www.centerragold.com/) Англи, Монгол хэл дээр тус тус байршуулна.

Эдгээр баримт бичгийн хэвлэмэл хувийг ЕСБХБ-ны Монгол болон Лондон дахь оффисууд, мөн Сентерра компанийн Монгол болон Канад дахь оффисуудаас авах боломжтой. Эдгээр баримт бичгийн хэвлэмэл хувийг аймаг, сум, багийн захиргаанд тус тус хүргүүлнэ. Сентеррагийн Канад болон Улаанбаатар дахь оффист, мөн Зүүнхараа, Баруунхараа болон Түнхэл багийн төвд байрлах Бороо гоулд компанийн олон нийтийн мэдээллийн төвүүд, үүнээс гадна Сэлэнгэ аймаг, Мандал сум, Баянгол сум болон Түнхэл багийн Засаг даргын тамгын газарт баримт бичгүүдийн хувийг байрлуулж сонирхсон талуудыг уншиж танилцах боломжоор хангана. Техникийн бус хураангуй болон олон нийтэд хийсэн танилцуулгын хувийг (Олон нийтэд танилцуулах уулзалтын үйл ажиллагааны

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ

дэлгэрэнгүйг доор үзнэ үү) дээр дурьдсан газруудад бүх сонирхогч талуудад хүртээмжтэй байдлаар тарааж, танилцуулга хийх газар/арга хэмжээн дээр авах боломжийг бүрдүүлнэ.

Төслийн бүсэд хийх танилцуулгыг Сентерра компани зохион байгуулна. Танилцуулах уулзалтуудыг зохион байгуулах баг Сентерра компанийн дээд удирдлага болон орон нутагтай харилцах багаас бүрдэх бөгөөд ингэхдээ Улаанбаатар хот, Мандал, Баянгол сумдууд, Түнхэл багт хийх уулзалтын үеэр олон нийтэд ил тод болгох багц материалыг ашиглана. Танилцуулах уулзалтууд нь оролцогч талуудад Төслийн байгаль орчин, нийгмийн асуудлуудын талаар сонирхсон асуултаа тавих, санал бодлоо илэрхийлэх боломж олгох давхар зорилготой.

Хүснэгт 6-д төслийн одоогийн болон цаашид хэрэгжүүлэх оролцогч талуудыг татан оролцуулах, тэдгээрийн оролцоог хангах үйл ажиллагааны төлөвлөгөөний хураангуйг харуулав. Уг төлөвлөгөөний дэлгэрэнгүй хувилбарыг компани нь дотооддоо ашигладаг.

Хүснэгт 6. Одоо болон ирээдүйд оролцогч талуудыг татан оролцуулах үйл ажиллагааны төлөвлөгөө

Үйл ажиллагаа	Ил тод болгох мэдээллийн төрөл	Уулзалт болох газар, огноо/харилцаа холбооны хэлбэр	Зөвлөлдөх шаардлагатай оролцогч талуудын бүлгүүд
БОННҮ-г олон нийтэд танилцуулах үе шат			
Энэхүү олон нийтэд танилцуулах багц материалтай танилцах боломжийг олгох үүднээс хэвлэмэл байдлаар байршуулах	Олон нийтэд танилцуулах багц дараах тайлангуудас бүрдэнэ, үүнд: • Техникийн бус хураангуй; • Хуулийн дагуу батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангууд; • Нийгмийн нөлөөллийн үнэлгээний тайлан; • Техник, эдийн засгийн үнэлгээний нэг хэсэг болох Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ; • Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (энэхүү төлөвлөгөөг багтаасан); • Гацууртын бүс нутгийн биет бус соёлын өвийн угсаатан зүйн тайлан	• Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын байр; • Мандал сумын ЗДТГ-ын байр; • Баянгол сумын ЗДТГ-ын байр; • Түнхэл багийн ЗДТГ-ын байр; • Зүүнхараа дахь Бороо гоулд компанийн Олон нийтийн мэдээллийн төв; • Баруунхараа дахь Бороо гоулд компанийн Олон нийтийн мэдээллийн төв; • Түнхэл баг дахь Бороо гоулд компанийн Олон нийтийн мэдээллийн төв; • Хэрх баг дахь Бороо гоулд компанийн Олон нийтийн мэдээллийн төв; • Улаанбаатар болон Канад дахь Сентеррагийн төв оффисууд; • Компанийн веб хуудас. Огноо: удахгүй баталгаажигдана. Дээр дурдсан газарт тайлангуудын хэвлэмэл хувийг байршуулна. Баримт бичгийг тухайн газарт байршуулахаас өмнө орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд (жишээ нь, олон нийтийн зориулсан мэдээллийн самбар, ухуулах хуудас, орон нутгийн сонин) мэдээлэл гаргах, мөн орон нутгийн засаг захиргаа,	• Бүхий л сонирхогч талууд

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ

		иргэдийн төлөөлөгчдөд (жишээ нь, Засаг дарга, ИТХ) мэдэгдэх зэргээр тайлангуудтай хаана танилцах боломжтой тухай олон нийтэд мэдээлэх болно.	
БОННҮ-ний хэлэлцүүлэг ба олон нийтэд танилцуулж зөвлөлдөх уулзалтууд	Төслийн БОННҮ-ний тайланг олон нийтэд танилцуулах багцад дараах бичиг баримт орно, үүнд: • Техникийн бус хураангуй; • Хуулийн дагуу батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангууд; • Нийгмийн нөлөөллийн үнэлгээний тайлан; • Техник, эдийн засгийн үнэлгээний нэг хэсэг болох Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ; • Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (энэхүү төлөвлөгөөг багтаасан); • Гацууртын бүс нутгийн биет бус соёлын өвийн угсаатан зүйн тайлан.	• Улаанбаатар; • Мандал сум (Зүүнхараа); • Баянгол сум (Баруунхараа); • Түнхэл багийн төв; • Хэрх багийн төв. Огноо: удахгүй баталгаажигдана. Тухайн орон нутагт тайлан танилцуулах уулзалт болохоос дор хаяж 2 долоо хоногийн өмнө оролцогч талуудад хэлэлцүүлэг, уулзалтын тухай орон нутгийн мэдээллийн хэрэгслээр (жишээ нь, олон нийтийн зориулсан мэдээллийн самбар, ухуулах хуудас, орон нутгийн сонинд мэдээлэл гаргах) зарлахаас гадна орон нутгийн засаг захиргаа, иргэдийн төлөөлөгчдөд (жишээ нь, Засаг дарга, ИТХ) мэдэгдэнэ.	• Засаг захиргааны байгууллагууд • ТББ-ууд • Орон нутгийн иргэд • Олон нийтийн бүлгүүд • Боломжит харилцагч үйлчлүүлэгчид • Нийт ард иргэд
Барилгын өмнөх үе шат			
Барилгын өмнөх ерөнхий төлөвлөлт, уурхайн талбайн бэлтгэл ажил	Уурхайн талбайн бүтээн байгуулалт болон бэлтгэл ажлын ерөнхий хуваарь, тэр дундаа дэд үйл ажиллагаанууд, гол үе шатууд болон оролцогч талуудын зүгээс сонирхол татах магадлалтай үе шат, тухайлбал замын ажил, ашиглалтын үе шат дахь уурхайн ажилчдын кемп	• Дэлгүүр, орон нутгийн оффис гэх зэрэгт байрлах олон нийтийн мэдээллийн самбарт мэдээлэл тавих • Хэвлэмэл материал, нэлттэй хаалганы уулзалтууд, олон нийтийн мэдээллийн самбаруудаар дамжуулан орон нутгийн бизнес эрхлэгчид/оршин суугчдад мэдээлэл хүргэх • Хэвлэлийн мэдээ, орон нутгийн телевиз, радио • Орон нутгийн иргэдтэй харилцах бүлгүүд, сар тутмын уулзалтууд • төслийн талбайн орчмын нөлөөллийн бүсэд бүтээн байгуулалт эхлэхээс өмнө Зөвлөлдөх хороог байгуулна.	Орон нутгийн иргэд Олон нийтийн бүлгүүд Нийт ард иргэд ТББ-ууд
Малчидтай хийх тусгайлсан хэлэлцүүлэг з	Нэмэлт мэдээллийн багц	бүтээн байгуулалт эхлэхээс өмнө болон цаашдаа тогтмол байдлаар зохион байгуулна	Малчид
Бичил уурхайчдын бүлгүүд эсвэл Монгол дахь тэднийг төлөөлөх эрх бүхий	Бичил уурхайн талаар санаа зовоосон асуудлаар хэлэлцүүлэг хийх	бүтээн байгуулалт эхлэхээс өмнө болон цаашдаа тогтмол байдлаар зохион байгуулна	Бичил уурхай эрхлэгчид болон/эсвэл тэдний төлөөлөл

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ

холбоодтой хийх хэлэлцүүлэг[7]			
Төслийн талбайн орчмын нийгмийн эмзэг бүлгүүдтэй хийх тусгайлсан хэлэлцүүлэг	Төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн тухай мэдээлэл хийх, ялангуяа барилгын үе шатанд хэрэгцээтэй ажиллах хүч, хөдөлмөр эрхлэх боломжууд, шаардлагатай ур чадвар, сургалтын боломжуудын талаар мэдээлэл өгөх	бүтээн байгуулалт эхлэхээс өмнө болон цаашдаа тогтмол байдлаар зохион байгуулна	Залуучууд/ эмэгтэйчүүд/ хөгжлийн бэрхшээлтэй иргэд
БАРИЛГЫН ҮЕ ШАТ			
Барилгынүе шатны тухай ерөнхий мэдээлэл	• Барилгын ажлын хуваарь • Барилгын ажил • Барилгын ажлын явц • Барилгын ажлаас үүдэлтэй нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ (тэр дундаа нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдээс санал бодлыг нь авах боломжоор хангах)	• Дэлгүүр, орон нутгийн оффис гэх зэрэгт байрлах олон нийтийн мэдээллийн самбарт мэдээлэл тавих • Хэвлэмэл материал, нэлттэй хаалганы уулзалтууд, олон нийтийн мэдээллийн самбаруудаар дамжуулан орон нутгийн бизнес эрхлэгчид/оршин суугчдад мэдээлэл хүргэх • Хэвлэлийн мэдээ, орон нутгийн телевиз, радио • Орон нутгийн иргэдтэй харилцах бүлгүүд, сар тутмын уулзалтууд	• ТББ-ууд • Орон нутгийн иргэд • Олон нийтийн бүлгүүд • Нийт ард иргэд
Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлаар зөвлөлдөх, мэдээлэл өгөх	• Барилгын үе шатанд хөдөлмөр эрхлэх боломжууд, хэрхэн ажилд орох хүсэлт гаргах тухай	• Дэлгүүр, орон нутгийн оффис гэх зэрэгт байрлах олон нийтийн мэдээллийн самбарт мэдээлэл тавих • Хэвлэмэл материал, нэлттэй хаалганы уулзалтууд, олон нийтийн мэдээллийн самбаруудаар дамжуулан орон нутгийн бизнес эрхлэгчид/оршин суугчдад мэдээлэл хүргэх • Хэвлэлийн мэдээ, орон нутгийн телевиз, радио • Орон нутгийн иргэдтэй харилцах бүлгүүд, сар тутмын уулзалтууд	• Орон нутгийн иргэд • Эмзэг бүлгүүд • Нийт ард иргэд
Ачааны тээврийн машины хөдөлгөөн, тээвэрлэлт хийх цаг гэх мэт мэдээлэл өгөх	Замын хөдөлгөөний талаарх мэдээлэл, ложистик, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, аюулгүй ажиллагаанд гарч болох гол эрсдлүүд	Удахгүй баталгаажуулна	• Орон нутгийн иргэд • Нийт ард иргэд • Холбогдох төрийн байгууллагууд
Орон нутагт хийх хөрөнгө оруулалтын төслүүддэр орон нутгийн засаг захиргаа, иргэд, ТББ-уудтай зөвлөлдөх	Орон нутгийг хөгжүүлэх болон хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөө, үйл явц	• Фокус бүлгийн уулзалтууд • Олон нийттэй хийх уулзалтууд • Судалгаанууд	• Орон нутгийн иргэд • ТББ-ууд, ОНОТБ-ууд • Эмзэг бүлгүүд • Орон нутгийн засаг захиргаа

[7] Энд талбай руу дайран орсон болон хууль бус олборлогчдыг оруулаагүй бөгөөд Нийгмийн менежментийн төлөвлөгөөнд эдгээр бичил уурхайчдад авах хэмжээг тодорхой заасан болно.

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ

Уурхайн талбай, түүний гадна болон эргэн тойронд гарч болох аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалтай холбоотой асуудлаар хийх тогтмол уулзалтууд	Уурхайн талбай болон түүний гадна, мөнн эргэн тойрон дахь аюулгүй ажиллагаатай холбоотой асуудлуудыг урьдчилан мэдэгдэх (боломжтой бол)	Удахгүй баталгаажуулна	• Орон нутгийн иргэд • Нийт ард иргэд • Онцгой байдлын газар
Нөлөөлөлд өртөж болзошгүй бүхий л оролцогч талууд хэрхэн компанитай холбоо тогтоож өргөдөл, гомдол гаргах (өргөдөл, гомдол барагдуулах журмын дагуу) талаар мэдээлэлтэй байхын тулд оролцогч талуудтай байнга зөвлөлдөж байх болно.	Өргөдөл, гомдлын механизмын талаар мэдээлэл өгөх	Удахгүй баталгаажуулна	• Бүх оролцогч талууд
АШИГЛАЛТЫН ҮЕ ШАТ			
Хөдөлмөр эрхлэх боломжууд	хөдөлмөр эрхлэх боломжууд, шаардлагатай ур чадвар, сургалт болон үзүүлэх дэмжлэг, мэдээллийн хүртээмж	Ажлын байрны тодорхойлолт, шаардлагатай ур чадварын талаар мэдээлэл/ мэдээллийн хуудас гэх мэт	• Бүс нутгийн болон орон нутгийн иргэд • Бүс нутгийн болон орон нутгийн бизнес эрхлэгчид
Ашиглалтын үе шатан дахь Компанийн гүйцэтгэл	Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөөний талаарх жил бүрийн шинэчлэгдсэн мэдээлэл, тайлан	• Компанийн тайлангууд • “Компанийн Нийгмийн хариуцлага”-ын хүрээнд хийсэн ажлын товч хураангуй • Компанийн вэб хуудсын хэсэг • Орон нутгийн оролцогч талуудын гаргасан асуудлуудыг авч хэлэлцэхийн тулд холбогдох хүмүүстэй хагас жил тутам хийх уулзалтууд (6 сар тутам нэг удаа) • Орон нутагтай харилцах бүлгүүд, сар бүрийн тогтмол уулзалтууд	• Компанийн дотоод оролцогч талууд • Орон нутгийн иргэд • Бэлтгэн нийлүүлэгчид • Харилцагчид
Сентерра компанийн хамгаалалтын алба нь Гацуурт талбайг хамгаалах бөгөөд илрүүлсэн хууль бус мод бэлтгэгчид/лицензийн талбайд хууль бусаар нэвтрэн орсон этгээд болон бичил уурхайчдыг хөөж гаргах арга хэмжээ авах болно.	Хууль бусаар мод бэлтгэхийн эсрэг компанийн зүгээс авах арга хэмжээний талаар мэдээлэл өгөх	• Удахгүй баталгаажуулна	• Хууль бус мод бэлтгэгчид • хууль бусаар нэвтрэн орсон этгээд болон бичил уурхайчид • Нийт ард иргэд • Орон нутгийн иргэд
Уурхайн хаалтын төлөвлөгөөний хүрээн дэх нийгмийн асуудлаар ажлын	Уурхайн хаалтын төлөвлөгөөний хүрээн дэх нийгмийн арга хэмжээнүүд, нэн тэргүүний асуудлууд	Удахгүй баталгаажуулна	• Орон нутгийн иргэд • Аймаг/сумын ЗДТГ

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ

хэсэг байгуулах, ажлын хэсэгтэй Хаалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө Төслийн ашиглалтын үе шатанд нарийвчилсан төлөвлөгөө боловсруулахаар хамтран ажиллах.	Уурхайн хаалтын төлөвлөгөө		• ТББ-ууд • Эмзэг бүлгүүд • Орон нутгийн бизнес эрхлэгчид ба холбоод
Ашиглалтын үе шатанд салбарын тухай ойлголт, мэдлэгийг түгээх зорилгоор сургууль, МСҮТ болон их дээд сургуулиудтай хамтран ажиллах	Сургалт/шаардагдах ур чадвар, хэрэгцээ Түншлэлийн боломжууд Сургах хүмүүс	Удахгүй баталгаажуулна	• МСҮТ • Их дээд сургуулиуд
Эрүүл мэндийн дэд бүтэц, үйлчилгээг сайжруулах, хяналт тавихын тулд засгийн газар, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.	Эрүүл мэндийн дэд бүтцийн шаардлага хэрэгцээ болон тулгарч буй асуудлууд	Удахгүй баталгаажуулна	• Сум, багийн удирдлага • ИТХ/багийн иргэдийн нийтийн хурал
Аулгүй байдал, хяналтыг хангаж зочдыг Төслийн талбайтай танилцуулах хөтөлбөр хэрэгжүүлэх	Уул уурхайн талаар ойлголт, мэдлэг, боловсрол олгох	Удахгүй баталгаажуулна	• Сонирхсон орон нутгийн иргэд
ХААЛТЫН ҮЕ ШАТ			
ОТТОТ-г хаалтын үе шатанд эргэн харж уурхайн хаалтын үед гол оролцогч талуудыг (орон нутгийн иргэд, засаг захиргаа, бичил уурхайчид, малчид гэх мэт) дахин тодорхойлж тэдгээртэй зөвлөлдсөний үндсэн дээр шинэчлэн боловсруулах болно.			

6 ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ БАРАГДУУЛАХ МЕНЕЖМЕНТ

Сентерра компани нь Монгол Улсад байгаа зочин гэдгээ ухамсарлан ойлгож байна. Бид Монгол Улс, Монголын ард түмэн, компанийн аль алинд нь үр ашигтайгаар ашигт малтмал олборлохоор зорьж байна. Компани нь уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрлүүдээс гадна нөлөөллийн бүс нутагт байгаа ард иргэдээр "үйл ажиллагаа явуулах эрхээ хүлээн зөвшөөрүүлэх" (буюу нийгмийн лиценз) ёстой гэдгийг ойлгож байна. Сентерра нь уул уурхайн төслүүдэд санхүүжилт олгодог олон улсын санхүүгийн байгууллагуудаас тогтоосон шилдэг туршлага, стандартуудыг мөрдөн ажилладаг.[8]

Уурхайн хайгуул, бүтээн байгуулалт, ашиглалт болон хаалтын үйл ажиллагааны нөлөөлөлд өртөж буй хүмүүсийн амьдралын хэв маяг, үнэт зүйлсийг бид хүндэтгэн үздэг. Компани нь нөлөөлөлд өртсөн иргэдтэй эерэг, чин сэтгэлийн, байнгын харилцаатай байхыг эрмэлзэж байна. Бид иргэдтэй харилцах харилцаа, хамтын ажиллагаагаа тасралтгүй сайжруулахын төлөө байна.

Сентерра нь орон нутгийн иргэдийн амьдралд нөлөөлж буй компанийн холбогдох үйл ажиллагааны талаар өргөдөл, гомдол гаргаж, түүнийг нь хүлээн авах, шийдвэрлэх үйл явц эдгээр иргэдэд хэрэгтэй

[8] Олон Улсын Санхүүгийн Корпорацийн Гүйцэтгэлийн Шаардлага (ГШ) 1-д өргөдөл, гомдлын механизмын талаар нарийвчлан заасан байдаг. Байгаль орчин, нийгмийн үнэлгээ болон менежментийн системийн тухай хэсэгт энэ тухай (5-6-р хуудас) зааснаар: *"Үйлчлүүлэгч нь төсөлтэй холбоотой иргэдийн асуудалд хариу өгөх шаардлагатай. Үйлчлүүлэгч нь нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдэд тогтмол эрсдэл бий болох эсвэл сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байгаа бол өөрийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны гүйцэтгэлтэй холбоотой өргөдөл, гомдол болон аливаа асуудлыг хүлээн авч шийдвэрлэх өргөдөл, гомдлын механизмыг бий болгоно."* Өргөдөл, гомдлын механизмын талаар "Гүйцэтгэлийн Шаардлага 2: Хөдөлмөр эрхлэлт ба хөдөлмөрийн нөхцөл", "Гүйцэтгэлийн Шаардлага 4: Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа ба аюулгүй байдал", "Гүйцэтгэлийн Шаардлага 5: Газар чөлөөлөлт ба албадан нүүлгэн шилжүүлэлт", болон "Гүйцэтгэлийн Шаардлага 7: Уугуул иргэд" зэрэг шаардлагуудад мөн тусгасан болно.

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ

гэдгийг ойлгож байна. Доор дурьдсан өргөдөл, гомдлын механизм нь бидний үйл ажиллагаагаа явуулдаг бүс нутгийн орон нутгийн иргэдийн өргөн хүрээний бүлгүүдтэй хийсэн хэлэлцүүлгийн үр дүн юм.

Сентерра нь Монгол Улсын хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх хууль, дүрэм журам, холбогдох хууль эрхзүйн актууд болоод Монгол Улсын Засгийн газрын давамгай байдлыг хүндэтгэн хүлээн зөвшөөрч байна. Энэхүү өргөдөл, гомдлын механизм нь Монгол Улсын хуулийг орлох эсвэл түүнийг халах зорилго агуулаагүй болно. Энэхүү механизм нь яриа хэлэлцээр болон бичгээр баталгаажуулах замаар тухайн асуудалд аль болох уул суурьтай хандах байдлаар шийдвэр олоход чиглэсэн компанийн зүгээс санал болгож буй үйл явц юм. Уг өргөдөл, гомдлын механизмыг Компани боловсруулж, туршиж үзсэн бөгөөд өмнө нь Бороо гоулд уурхай дээр ашиглаж байсан. Энэхүү механизмыг уурхайн барилга, ашиглалт, хаалтын үе шатуудад үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээс гадна уурхайн хаалтын дараах үе шатанд мөн адил ашиглах боломжтой юм.

Сентерра компани ажилчдын зүгээс ажлын байртай холбоотой зохих асуудлыг дэвшүүлэх боломжоор хангах үүднээс өөрийн ажиллагсад, гэрээт ажилтнуудад (болон тэдгээрийг төлөөлөх байгууллагуудад) зориулсан дотоод өргөдөл, гомдлыг барагдуулах механизмтыг хэрэгжүүлдэг. Компани ажилчдыг ажилд авах үеэд уг механизмын талаарх мэдээллийг өгөхийн зэрэгцээ түүнд хандах боломжоор хангах болно. Уг механизмын хүрээнд аливааа шийтгэл ногдуулахгүйгээр холбогдох хүмүүст санал бодлоо илэрхийлэх ойлгомжтой, ил тод процессыг ашиглан асуудлыг зохих түвшинд зохицуулах, түүнийг шуурхай шийдвэрлэх болно. Уг механизм нь хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулт эсвэл арбитрын журмын дагуу бусад шүүхийн эсвэл захиргааны механизмуудад хандахад саад учруулах, эсвэл хамтын гэрээ хэлэлцээрт заасан гомдол барагдуулах механизмыг орлуулах зорилго агуулаагүй болно.

6.1 Зорилго

Энэхүү өргөдөл, гомдлын механизмд өргөдөл, гомдол барагдуулах шийдлийг олох зорилгоор Компани, орон нутгийн иргэд хэрхэн хамтран ажиллах арга замыг тайлбарласан болно. Уг механизм нь ямар нэг айдасгүйгээр аливаа асуудлыг шударгаар хянан үзэх, мэдээлэл авах, хэргийг шударгаар шийдвэрлэх боломжийг олгодог.

6.2 Зорилтууд

- Өргөдөл, гомдол гаргагчийн соёл, үнэт зүйлс, уламжлал, үзэл бодолд нь хүндэтгэлтэй хандах;
- Өргөдөл, гомдлыг орон нутгийн түвшинд цаг алдалгүй шийдвэрлэх;
- Өргөдөл, гомдлын үндсэн суурь шалтгааныг тодорхойлж системд хамаарах асуудлыг шийдвэрлэх;
- Компани нь өргөдөл, гомдлын дагуу асуудлыг судлах, хэлэлцэх, шийдвэрлэх, гомдлын дагуу авсан арга хэмжээ, үр дүнг мэдээлэх чиглэлээр өргөдөл, гомдол гаргагчтай харилцан ярилцах байдлаар асуудлыг шийдэх;
- Өргөдөл, гомдлыг шударга, тэгш, тууштай байдлаар шийдвэрлэх;
- Тухайн орон нутгийн иргэдийн асуудлыг шударгаар шийдвэрлэхийн тулд Компанийн чадавхийг тогтмол сайжруулж бэхжүүлэх.

6.3 Хамрах хүрээ

Өргөдөл, гомдлын механизм юуны түрүүнд орон нутгийн иргэдэд компанийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар санал бодлоо хэлэх арга хэрэгсэл болох юм. Иргэдээс хөндөж байгаа асуудлууд нь уурхайн талбайн доторх болон эргэн тойронд байгаа компанийн үйл ажиллагаатай шууд холбоотой байвал зохино. Тухайн асуудлыг компанийн үйл ажиллагааны улмаас шууд нөлөөлөлд өртсөн хувь хүн эсвэл хэсэг хүмүүс гаргаж тавивал зохистой. Энэхүү механизм нь Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журмыг хүндэтгэн үзэж түүнд нийцсэн болно. Компани нь асуудлыг шүүх, эсвэл үндэсний хэмжээний бусад арга механизмд шилжүүлж хүндрэхээс өмнө орон нутгийн түвшинд шийдвэрлэхийг чармайна.

6.4 Өргөдөл, гомдол барагдуулах механизм хэрэгжих үйл явц

1 Өргөдөл, гомдлыг бүртгэж авах:

- Өргөдөл, гомдлыг бичгээр, и-мэйл, факс, эсхүл компанийн өргөдөл, гомдлын маягт дээр бичиж өгөх боломжтой (Хавсралт 1-ийг үзнэ үү):

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ

- Хандах газар: Орон нутгийн харилцааны хэлтэс, Сентерра Гоулд ХХК
- Шуудангийн хаяг: Бодь цамхаг, 11-р давхар, Их ззэн Чингис хааны нэрэмжит талбай, шуудангийн хайрцаг 223, Улаанбаатар 15160, Монгол Улс
- Утас: +976-11-317798
- Факс: +976-11-316100
- Цахим шуудангийн хаяг: Enkhtuul.j@centerragold.mn
- Компанийн веб хуудас: www.centerragold.com; www.boroogold.mn

- Гомдлыг амаар гаргаж болох бөгөөд энэ тохиолдолд орон нутгийн харилцааны ажилтан (эсвэл компанийн бусад холбогдох төлөөлөгч) гомдлыг бүртгэн авч баримтжуулна. Амаар гаргасан гомдлыг орон нутгийн харилцааны ажилтан бүртгэн авахдаа гомдол гаргагчаар өргөдөл, гомдол хүлээн авах маягт дээр гарын үсэг зуруулан түүний зөвшөөрлийг авна. Гомдол гаргагч бичиг үсэг тайлагдаагүй бол орон нутгийн харилцааны ажилтан гуравдагч этгээдээр (гомдол гаргагчийн найз/хамаатан) гомдлын агуулгыг шалгаж эсвэл баталгаажуулан өргөдөл, гомдол хүлээн авах маягт дээр гарын үсэг зуруулж болно.
- Гомдолд тухайн гомдлын агуулга, гомдол гаргасан огноо, гомдол гаргагчийн нэр, холбоо барих утас зэргийг дурдсан байх хэрэгтэй.
- Таны байгаа газарт компанийн орон нутгийн харилцааны ажилтан байгаа бол, албан ёсоор гомдол гаргахын өмнө тухайн өргөдөл, гомдлын талаар ярилцаж болно.
- Өргөдөл, гомдлыг нэрээ нууцлан эсвэл гуравдагч этгээдээр (жишээ нь, ТББ-ууд, орон нутгийн захиргаа, ахмадын хороо гэх мэт) дамжуулан гаргах боломжтой.
- Хувь хүмүүс өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх явцад нэрээ нууцлах хүсэлт гаргах эрхтэй.
- Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн өргөдөл, гомдлоо өөр өөр байдгаас гадна гомдлоо өөр өөр байдлаар гаргадаг тул гомдол гаргагч нь компанийн эрэгтэй/эмэгтэй төлөөллөөр дамжуулан өргөдөл, гомдлоо барагдуулах хүсэлт гаргаж болно. Ийм хүсэлт гаргасан тохиолдолд Сентерра нь уг хүсэлтийг аль болох биелүүлэхийг хичээх болно.

2 Өргөдөл, гомдлыг хүлээж авснаас хойш 7 хоногийн дотор Компани:

- Өргөдөл, гомдлыг хянахын тулд Компанийн өргөдөл, гомдлын бүртгэлийн системд оруулж бүртгэнэ;
- Тодорхой шалгуурын дагуу өргөдөл, гомдлыг үнэлэх, хэрэв шаардлагатай бол тухайн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх зохистой арга боловсруулах;
- Өргөдөл, гомдол хэрхэн барагдуулж байгаа тухай хариу өгөх компанийн ажилтны нэр, өргөдөл, гомдлыг судлах, хэлэлцэх, шийдвэрлэхэд шаардлагатай алхмуудыг тайлбарласан тайлбар, асуудлыг шийдэхэд шаардагдах хугацааг урьдчилсан байдлаар заасан Өргөдөл, гомдлыг бичгээр хүлээн авсан тухай маягтыг өгнө.

3 Өргөдөл, гомдол шийдвэрлэх явц:

Компанийн өргөдөл, гомдол шийдвэрлэх асуудал хариуцсан зохицуулагч дараах арга хэмжээг авна, үүнд:

- Тухайн гомдол гаргасан асуудалд оролцсон талуудыг тодорхойлох;
- өргөдөл, гомдолд тусгасан асуудлын тухай гомдол гаргагчаас шууд асууж лавлан тодруулах;
- Гомдолд тусгасан асуудал хэр ноцтой, хувь хүн эсвэл хэсэг бүлэг хүмүүсийн сайн сайхан байдал, аюулгүй байдалд хэр ноцтойгоор нөлөөлж байгаа зэргийг харгалзан ангилах;
- Гомдолд хөндсөн асуудлаар туршлагатай ажилтнуудаас бүрдсэн бүлгийг хуралдуулах;
- Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, тухайлбал гомдлыг барагдуулах дараах хамгийн түгээмэл арга замыг эрэлхийлж болох юм, үүнд:
  - Компанийн зүгээс шийдлийг санал болгох;
  - Компани болон орон нутгийн иргэд хамтдаа шийдлийг олох;
  - Компани болон орон нутгийн иргэд шийдэл олохоор гуравдагч этгээдэд хандах;
  - Компани болон орон нутгийн иргэд орон нутгийн заншил эсвэл уламжлалт туршлагыг ашиглах гэх мэт.
- Бусад оролцогч талуудаас, тэр дундаа компанийн ажилтнуудын санал бодлыг сонсох, шаардлагатай бол төвийг сахисан мэргэжлийн дүгнэлт гаргуулах;
- Талуудын хэлэлцэж тохирсон асуудлыг шийдэх эхний хувилбаруудыг харгалзан үзэж янз бүрийн арга замыг эрэлхийлэх;
- Харилцан тохиролцсоны дагуу гомдол барагдуулах үйл явц буюу процессыг эхлүүлэх;

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ

- Өргөдөл, гомдлыг хаах маягт дээр гарын үсэг зурснаар гомдлыг хаах (өөрөөр хэлбэл хоёр тал шийдвэрийг хүлээн зөвшөөрсөн бол);
- Компани нь тухайн гомдол гаргагч үр дүнд сэтгэл хангалуун биш байсан ч гэсэн гомдлыг "хааж" болно. Гомдол гаргагч нь гомдол гаргасан асуудлаа нотолж чадахгүй байгаа, эсвэл илт залилан мэхлэх оролдлого хийж байгаа тохиолдолд Компани энэхүү сонголтыг хийх болно. Энэ тохиолдолд Компанийн зүгээс гомдлыг судалж дүгнэлт гаргасан бүхий л үйл явцыг сайтар баримтжуулж, гомдол гаргагч этгээдэд нөхцөл байдлын талаар тайлбарлаж өгнө. Сентерра (эсвэл түүний туслан гүйцэтгэгчид) нь тухайн гомдол гаргагчид мэдэгдэх болон нэмэлт мэдээлэл/нотлох баримт өгөх боломжийг олгоогүй тохиолдолд аливаа өргөдөл, гомдлыг өнгөц байдлаар шийдвэрлэж түүнийг хаахыг хориглоно.;
- Гомдол тус бүрээр түүнийг шийдвэрлэх явц, харилцаа холбооны талаархи тэмдэглэлийг хөтөлж хадгална.

6.5 Өргөдөл, гомдол шийдвэрлэх хугацаа

Компани нь гомдол хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор асуудлыг шийдэхийг эрмэлзэх болно. Сентерра компани өргөдөл гомдлыг хүлээн авснаа гомдол гаргагчид 7 хоногийн дотор мэдэгдэж, 30 хоногийн дотор асуудлыг шийднэ. Асуудлыг шийдэхэд 30 хоногоос илүү хугацаа шаардагдахаар байгаа бол гомдол гаргагчид хугацааг хойшлуулах болсон шалтгаан, гарсан ахиц болон хүндрэл, шийдвэр гаргах боломжтой хугацааг амаар эсхүл бичгээр мэдэгдэнэ.

Зураг 2: Өргөдөл, гомдол шийдвэрлэх үйл явц



ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ

6.6 Өргөдөл, гомдол шийдвэрлэх механизмын тухай нийтэд мэдээлэх

Өргөдөл, гомдол шийдвэрлэх механизмын талаар дараах байдлаар олон нийтэд мэдээлнэ. Үүнд:

- Энэхүү оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөө;
- Орон нутгийн хэвлэл мэдээлэл;
- Орон нутгийн зарлалын салбар;
- Иргэдтэй хийх уулзалтын үеэр;
- Орон нутгийн ИТХ болон Засаг даргад уламжлах; болон
- Орон нутаг/Компанийн Хамтарсан ажлын хэсэгт тогтмол тайлагнах зэргээр.

6.7 Өргөдөл, гомдол барагдуулах үйл явц хангалттай байсан гэдгийг хүлээн зөвшөөрөх

Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх шатанд кКомпани тухайн гомдол гаргагч асуудлыг шийдвэрлэсэн үр дүнд сэтгэл хангалуун биш байсан ч өргөдөл, гомдол шийдвэрлэх үйл явц хэр хангалттай байсан талаар уг гомдол гаргагчаар үнэлүүлж тусгай маягтыг бөглүүлнэ (Хавсралт 2-г үзнэ үү). Энэхүү маягтад гомдол барагдуулах механизмын зорилгыг тусгаснаас гадна гомдол гаргагчийн хувьд гомдол шийдвэрлэх үйл явц компанийн зорилготой нийцэж байгаа эсэх талаар асуусан асуултыг тусгасан байдаг. Тухайлбал дараах асуултуудыг асууна, үүнд:

- Компани болон түүний төлөөлөгч хүндэтгэлтэйгээр хандаж байсан уу?
- Компани нь гомдлыг тухайн орон нутгийн хэмжээнд шийдвэрлэхийн тулд чадах бүхнээ хийсэн үү?
- Компани нь Таны гаргаж тавьсан асуудлын суурь шалтгааныг олж тогтоохыг хичээж байсан уу?
- Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад Та өөрийгөө эрх тэгштэй түншлэгч шиг мэдэрч байсан уу?
- Таны өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн шийдвэр нэг нутагт гаргасан ижил төстэй шийдвэртэй хэр нийцэж байна вэ, шийдвэр шударга байна уу?

Уг санал нь Компанийн зүгээс өргөдөл, гомдол барагдуулах механизмыг сайжруулж боловсронгуй болгоход тус дэм болно.

6.8 Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх бусад боломжууд

Гомдол гаргагч гаргасан шийдвэрт сэтгэл хангалуун бус байвал Компани нь өргөдөл, гомдлыг шийдвэрлэх өөр механизмын хүрээнд асуудлыг шийдэх чиглэлээр амтран ажиллана. Давж заалдах механизм нь өргөдөл, гомдлын мөн чанараас хамааран өөр өөр байна. Жишээ нь, хэрэв хуулийн дагуу асуудлыг шийдэх шаардлагатай бол асуудлыг шүүхэд шилжүүлнэ. Шаардлагатай бол, асуудлаар Монгол Улсын уул уурхай, байгалийн нөөцийн зөрчилдөөнийг шийдвэрлэх гурван талт зөвлөлд хандаж болно.

Гомдлыг шийдвэрлэх үйл явцад бие даасан хөндлөнгийн талуудыг урьж оролцуулах шаардлага гарч болно. Тухайлбал, орон нутгийн хуулийн байгууллагууд, хүлээн зөвшөөрөгдсөн ТББ, эсвэл орон нутагтаа нэр хүндтэй иргэдийг урьж оролцуулж болно. Хэдийгээр гаргасан шийдвэр нь зохих өргөдөл, гомдлын механизмын дагуу шийдвэрлэгдсэн боловч гомдол гаргагч уг шийдвэрт сэтгэл хангалуун бус байгаа бол асуудлыг шийдвэрлэхэд бусад хөдлөнгийн талуудыг оролцуулж болох юм. Эдгээр талууд дор дурдсан нэг эсвэл хоёр зорилт /чиг үүрэгтэйгээр оролцож болох юм. Үүнд:

- Зуучлах, өөрөөр хэлбэл хоёр тал хүлээн зөвшөөрсөн шийдэлд хүрэхийн тулд аль аль талуудын хүчин чармайлтыг дэмжих;
- Заавал биелүүлэх шаардлагатай арбитрын шийдвэр гаргах, өөрөөр хэлбэл хоёр тал бие даасан хөндлөнгийн арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрнө гэсэн үг.

6.9 Компани дотор өргөдөл, гомдлыг удирдах, дүн шинжилгээ хийх, урьдчилан таамаглах

Компани нь өргөдөл, гомдол барагдуулах механизмын хэрэгжилтийг хянах ахлах менежерийг томилно. Уг механизмыг хэрэгжүүлэхэд шаардлагатай өдөр тутмын ажлыг хариуцах нэг ажилтныг томилох бөгөөд тэрбээр өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд зөвлөлдөх мэргэжилтэн болон бие даасан хөндлөнгийн талуудыг (Бүлэг 6.8-г үзнэ үү) татан оролцуулах юм. Сентерра компанийн орон нутгийн харилцааны ажилтнууд гомдлын мөн чанараас хамаарч компанийн хүрээнд холбогдох хэлтсүүдтэй хамтран ажиллана. Тухайлбал, аюулгүй байдалтай холбоотой гомол хүлээж авбал орон нутгийн харилцааны ажилтан уг гомдлыг шийдвэрлэхийн тулд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн хэлтэстэй хамтран ажиллана.

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ

Компани нь өргөдөл, гомдлын бүртгэлийг хөтлөнө. Өргөдөл, гомдлыг хүлээн авч бүртгэх, асуудлыг шийдэх үйл явцаас үр дүн хүртэлх бүхий л арга хэмжээг энд бүртгэнэ.

Компани нь гомдол, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаар бүх ажилтнуудад мэдээлж байхад анхаарч ажиллана.

Өргөдөл, гомдлын хандлага, системийн асуудал болон ижил төстэй өргөдөл, гомдлын давтамжийг харахын тулд улирал бүр энэхүү бүртгэлд дүн шинжилгээ хийнэ. Компани нь ижил төстэй гомдлын суурь шалтгааныг судалж үндсэн болон ерөнхий асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авах болно. Өргөдөл, гомдлын механизмыг ашиглаж байсан иргэдээс авсан санал зөвлөмжийг цаашид уг механизмыг боловсронгуй болгоход ашиглана.

Компани нь гомдол барагдуулах механизмыг ажиллуулж үүнийг ашиглах боломжтой тухай олон нийтэд байнга сануулж байх болно.

Гэрээт гүйцэтгэгчид энэхүү өргөдөл, гомдол барагдуулах журмыг мөн адил мөрдөх шаардлагатай. Гэрээт гүйцэтгэгчид Сентерра компанийн гомдол шийдвэрлэх үйл явцад идэвхтэй оролцох ёстой. Гэрээт гүйцэтгэгчид гомдол шийдвэрлэх үйл явцад оролцсолноор тухайн гэрээт гүйцэтгэгчтэй холбоотой гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэх боломж бүрдэх юм.

Гэрээт гүйцэтгэгчид өөрсдийн ажилтан бүр Сентерра компанийн гомдол барагдуулах журмын тухай мэдээлэл өгч танилцуулах үүрэгтэй байна. Гэрээт гүйцэтгэгчид хувь хүн, эсвэл орно нутрий иргэдээс гаргасан аливаа гомдлыг хүлээн авч нэн даруй Сентеррад энэ тухай мэдэгдэнэ. Гэрээт гүйцэтгэгчид Сентерра компанитай урьдчилан тохиролцолгүйгээр орон нутгийн иргэдтэй аливаа шууд гэрээ хийх, шийдвэр гаргахаас татгалзана.

Гэрээт гүйцэтгэгчийн орон нутгийн харилцааны баг (эсвэл ижил төстэй чиг үүрэг бүхий нэгж) Сентерра компаниас зохион байгуулах өдөр, долоо хоног тутмын зохицуулалт хийх хуралд оролцохын зэрэгцээ нэн яаралтай хийх хуралд заавал оролцоно. Гэрээт гүйцэтгэгчийн орон нутгийн харилцааны баг (эсвэл ижил төстэй чиг үүрэг бүхий нэгж) Сентерра компанийн Орон нутгийн харилцааны хэлтэст долоо хоног бүр, нэн яаралтай тохиолдолд орон нутаг, иргэдтэй холбоотогоор гарсан асуудлыг тэр даруй мэдэгдэнэ. Сентерра компани уг Өргөдөл, гомдол барагдуулах журмыг гэрээт гүйцэтгэгчид хэрхэн дагаж мөрдөж байгаад тогтмол аудит хийх болно.

7 КОМПАНИТАЙ ХОЛБОО БАРИХ

Компанитай хэрхэн холбоо барих тухай мэдээллийг доорх Хүснэгт 7-д тусгав.

	Дэлгэрэнгүй
Компанийн нэр	Сентерра Голд
Хандах нэгж	Орон нутгийн харилцааны хэлтэс
Шуудангийн хаяг	Бодь цамхаг, 11-р давхар, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай, шуудангийн хайрцаг, Улаанбаатар 15160, Монгол Улс
Утас	+976-11-317798
Факс	+976-11-316100
Цахим шуудан	Enkhtuul.j@centerragold.mn
Компанийн веб хуудас	www.centerragold.com; www.boroogold.mn

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ

Хавсралт 1: Маягт 1 “Өргөдөл, гомдол хүлээн авах хуудас”

Дугаар	
Огноо:	*Он сар өдөр*
Өргөдөл, гомдол гаргагчийн овог, нэр:	
Өргөдөл, гомдол гаргасан хүний оршин суугаа хаяг:	*Аймаг, сум, баг/тосгон, газрын нэрийг бичих*
Утас (гар):	
Утас (гэрийн):	
Имэйл хаяг:	
Өргөдөл, гомдол гаргах болсон асуудал (юу тохиолдсон бэ?):	
Хэзээ болов:	*огноо*
Давтамж:	*Өдөр тутам/ долоо хоног бүр /сар болгон*
Хаана (гомдол гаргах асуудал хаана гарсан):	*Аймаг, сум, баг/тосгон, газрын нэрийг бичих*
Хэн оролцсон:	*Нэр, албан тушаал, тодорхойлолт (хэрэв мэдэж байгаа бол)*
Энэ асуудал нь компанид яагаад хамааралтай вэ:	
Таны санал болгож буй/хүсч буй шийдэл:	

Зөвхөн албан хэрэгцээнд:		
Гомдол хүлээн авсан компанийн ажилтан:	*Нэр/албан тушаал*	
Шийдвэрлэсэн нь – ХҮЛЭЭН АВСАН:	**Ангилал:**	
	Дараагийн алхмууд:	
Шийдвэрлэсэн нь – ТАТГАЛЗСАН:	**Шалтгаан:**	
Өргөдөл, гомдол гаргасан хүний гарын үсэг:		
Хүлээн авсан ажилтны гарын үсэг:		

ХЭВЛЭГДСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТААС ГАДУУР БОЛНО. ХАМГИЙН СҮҮЛИЙН ХУВИЛБАРЫГ ГАЦУУРТЫН ЦАХИМ ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ

Хавсралт 2: Маягт 2 “Шийдвэрийг хүлээн зөвшөөрсөн тухай хуудас”

Дугаар	
Өргөдөл, гомдол гаргагчийн овог, нэр:	
Өргөдөл, гомдол гаргагчийн оршин суугаа хаяг:	*Аймаг, сум, баг, гудамж/барилга, хашаа/ орон сууц*
Доор байгаа асуулт тус бүрийн хариултыг тэмдэглэнэ үү:	
1. Компани болон/эсвэл түүний төлөөлөгч Тантай хүндэтгэлтэйгээр хандаж байсан уу?	ТИЙМ □ ҮГҮЙ □
2. Компани нь өргөдөл, гомдлыг орон нутагт нь шийдвэрлэхийн тулд бүхий л арга хэмжээг авч чадсан уу?	ТИЙМ □ ҮГҮЙ □
3. Компани нь тавьсан асуудлын суурь шалтгааныг судалсан уу?	ТИЙМ □ ҮГҮЙ □
4. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад Та өөрийгөө эрх тэгштэй түншлэгч шиг мэдэрч байсан уу?	ТИЙМ □ ҮГҮЙ □
5. Таны өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн шийдвэр нэг нутагт гаргасан ижил төстэй шийдвэртэй хэр нийцэж байна вэ, шийдвэр шударга байна уу?	ТИЙМ □ ҮГҮЙ □
Гарын үсэг	
Огноо:	